



**“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМГИЙН БАЯН-ӨНДӨР СУМЫН НУТАГТ
БАЙРЛАХ КАТОДЫН ЗЭСИЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН**


/Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: UN-000001/
/Регистрийн дугаар: 2788705/


Хянасан:

БОУАӨЯ ХБОБЗГ-ын мэргэжилтэн _____ /...../

Биелэлтийг тайлагнасан:

“Ачит-Ихт” ХХК-ийн үйлдвэрийн захирал  /И.Батболд/

“Ачит-Ихт” ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн менежер  /Б.Нэмэхбаяр /

“Ачит-Ихт” ХХК-ийн ХАБЭАБО-ны хэлтсийн байгаль орчны ажилтан  /Г.Намуунгэрэл/

2025он

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл	3
1.2. Төслийн түүхэн товчоо.....	3
1.3. Үйлдвэрийн үйл ажиллагаа, барилга байгууламжууд.....	4
2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ЗАСАГ, ЗАХИРГААНЫ ХАРЬЯАЛАЛ.....	5
2.1. Төслийн байршил:.....	5
2.2. Төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох зөвшөөрлүүд	5
3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	6
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
2.1. Агаарын чанарт үзүүлэл нөлөөллийг бууруулах.	9
2.2. Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах	10
2.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ	13
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	14
7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	16
8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ.....	18
9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ.....	19
10. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ.....	21

1. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл

Хүснэгт 1. Ачит-Ихт ХХК-ийн аж ахуйн нэгжийн мэдээлэл

Төслийг хэрэгжүүлэгч	Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	Төслийн байршил хаяг	Төсөл хэрэгжүүлэгчийн Хаяг байршил
Ачит-Ихт ХХК	9011190055	Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах ТӨҮГ-н 2-р овоолгыг түшиглэн катодын зэс үйлдвэрлэх	Эрдэнэт хотоос 15 км, уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэрээс 4км-т хойд өргөргийн 49°1'18", Зүүн уртрагийн 104°10'58" координат буюу Орхон аймгийн Баян-Өндөр сум, Баянцагаан багийн нутагт, Төмөр замын Эрдэнэт өртөөнөөс 5км зайд оршино.	Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, Кей Би Таур, 21 давхар Утас: 75951155

1.2. Төслийн түүхэн товчоо

Төсөл эхэлсэн огноо: Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь балансын бус хүдрийн хоёрдугаар овоолгод 1978 оноос 2005 оны хооронд 0.307%-ийн агуулгатай 199.230 тн металл зэстэй, 65.0 сая тн хүдэр байршуулсан. “Ачит-Ихт” ХХК хүдрийн нөөцийг шүлтгүйжүүлэлтийн технологиор боловсруулах арга замыг бүх талаас нь судалсны үндсэнд үйлдвэр байгуулах шийдвэр гаргаж, 2014 оны 5/330-14 тоот гэрээгээр 0.31%-ийн агуулгатай 173,998.9 тн металл зэстэй 56.0 сая тн балансын бус хүдрийг шилжүүлэн авсан.

Хүснэгт 2. Үйлдвэрийн түүхий эдийн нөөц, түүнээс гаргаж авах зэсийн хэмжээ:

№	Үзүүлэлт	Нэгж	Хэмжээ	
1	Үйлдвэрийн балансад авсан хүдрийн нөөц	Хүдэр	мян. тн	56000.9
		Эзлэхүүн	мян. м ³	29699.72
		Зэс	тн	173998
		Агуулга	%	0.31
2	Үүнээс 1983-2004 оны хооронд угаагдаж ул хөрсөнд суусан зэс	тн	1782	
3	2017 оны 7-р сарын 1 -д батлагдсан нөөц овоолгод үлдсэн зэс	тн	135668.8	
3.1	Хүдэр	Мян.м3	29699.7	
3.2	Исэлдсэн зэс	тн	26219	
		%	19.3	
3.3	Ашиглалтын бүх хугацаанд гаргах катодын зэс	тн	86056	

Төсөл хэрэгжих хугацаа: 52.0%-ийн зэс авалттайгаар 10 жилийн туршид 86056 тн катодын зэс гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Төслийн техник эдийн засгийн үндэслэл:

1. 2014 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 14-15-08 тоот дүгнэлтээр хүлээн авч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт орших “Ачит-Ихт” ХХК-ийн Катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэлийг хэлэлцэж, 2014 оны 10 дугаар

сарын 28-өдрийн Ашигт малтмалын газрын даргын Т-37 тоот тушаалаар Катодын зэсийн үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл батлагдсан.

2. 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар төслийн техник эдийн засгийн үндэслэлийн тодотголыг хэлэлцүүлэн БУ-2019-01-01 тоот дүгнэлтээр хүлээн авсан.

1.3. Үйлдвэрийн үйл ажиллагаа, барилга байгууламжууд

1. Үндсэн хүдрийн 2-р шороон овоолго
2. Нуруулдан уусгалтын овоолго
3. Хандлах цех
4. Электролизийн цех
5. Уурын зуух
6. Засварын газар
7. Насосын байрууд
8. Химийн бодисын агуулах
9. Материалын агуулах
10. Хүхрийн хүчлийн агуулах
11. Уусмал хадгалах цөөрмүүд
12. Үйлдвэрийн захиргаа, оффис



2025 онд үйлдвэрийн аюулгүй ажиллагааг хангах, осолгүй байх, ажиллах орчинг сайжруулах, нарны эрчим хүчийг ашиглан сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор үйлдвэрийн эрчим хүчний системтэй зэрэгцээ ажиллах On-grid 16.2кВт-ын нарны цахилгаан станцыг байгуулахаар төлөвлөж байна.


Үр дүн: 23.588 кВт.ц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 20,895 кг CO₂ буюу угаарын хийн ялгаралтаас сэргийлнэ.

2. ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ЗАСАГ, ЗАХИРГААНЫ ХАРЬАЛАЛ

2.1. Төслийн байршил:

Катодын цэвэр зэс боловсруулах үйлдвэр нь Эрдэнэт хотоос 15 км-т, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянцагаан багийн нутаг дэвсгэр, Эрдэнэт үйлдвэрийн үйлдвэрийн бүсэд байрлана. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь Эрдэнэт үйлдвэрийн эзэмшлийн талбайн 157.16 га-д явуулна.

Зураг 1. Төслийн байршилын зураг



Төслийн ангилал: Ачит-Ихт ХХК-н үйлдвэр зэсийн бага агууламжтай 2-р овоолгоос L-SX-EW технологи ашиглан катодын цэвэр зэс гаргаж авах төсөл бөгөөд 2014 оноос үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн, тогтмол явагдаж байна.

2.2. Төслөөс байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан, холбогдох зөвшөөрлүүд

Хүснэгт 3. Ачит-Ихт ХХК-ийн эзэмшдэг зөвшөөрлүүд, улсын байгууллагын дүгнэлтүүд

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	Дугаар	Огноо
1.	Аж ахуйн нэгжийн гэрчилгээ	9011190055	2014.02.28
2.	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл	0001624 0001625	2020.04.21- 2023.12.31
3.	Газрын чанарын хянан баталгаа		2015 2020
4.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт	11/2656 13/4334	2016.05.03 2019.06.20
5.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ	БОАЖНХЯ	2016.07.08
6.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол	БОАЖНХЯ	2017.05.31 2019.06.18

7.	Газар эзэмшүүлэх гэрээ	5/330-14	2014.09.08
8.	Ус ашиглуулах дүгнэлт Ус ашиглуулах дүгнэлт Ус ашиглах гэрээ	01 01 07	2022.02.15 2021.04.02 2022.02.14
9.	Химийн бодисын агуулахын магадлалын ерөнхий дүгнэлт	119/2017	2017.04.03
10.	Химийн бодисын агуулахын баталгаажуулалт. /Улсын байцаагчийн дүгнэлт/	14-04-004/160	2017.12.12
11.	Химийн бодис хадгалах агуулахын байршил тогтоох захирамж	А/640	2014.12.09
12.	Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт	01804849 01804848 01804847 01804846	2024.02.27- 2025.02.27

3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү төлөвлөгөөг боловсруулахдаа 2025 онд “ЖЭМР” ХХК-ийн боловсруулсан катодын аргаар зэсийг боловсруулж, үйлдвэрлэх төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тодотгол тайланд тусгасан төсөл хэрэгжүүлэгчийн хүлээх үүрэг амлалт, үүнээс гадна Монгол Улсын Байгаль орчны багц хууль, холбогдох дүрэм журам, стандартуудын шаардлагуудыг удирдлага болгон уг төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хугацаа, хөрөнгө зардлыг бодитойгоор тооцож тусгах зорилт тавилаа.

Бид 2025 оны БОАЖ-ын сайдын тушаалаар баталсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”, Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээний үр дүн зэргийг удирдлага болгон ажиллаж байна. 2025 оны Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээ, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийт **158,348,000 /нэг зуун тавин найман сая гурван зуун дөчин найман мянга/** төгрөг төсөвлөсөн байна.

Хүснэгт 4. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардлын задаргаа, төсөл тус бүрээр

№	Төслийн нэр	Төлөвлөсөн ажил /тоо хэмжээ/	Зардал
1	Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, нөлөөллийг бууруулах арга хэмжээ	15	65 200,000
2	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	3	3,100,000
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	3	37,568,000
4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	7	4,000,000
5	Хог хаягдлын менежмент	8	28,600,000
6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	10	8,880,000
7	Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	3	10,000,000
8	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь	5	1,000,000
Нийт		54	158,348,000

1. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

“Катодын зэсийн үйлдвэр” төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх эерэг ба сөрөг нөлөөлийг 2025 онд хийгдсэн БОНБНҮ-ий нэмэлт тодотгол тайланд дараах байдлаар тодорхойлсон байна. Катодын зэсийн үйлдвэрийн төсөл нь 0.24%-ийн агуулгатай балансын бус хүдрийн овоолгоос шүлтгүйжүүлэлт-хандлалт электролизын аргаар катодын зэс үйлдвэрлэнэ.

Шүлтгүйжүүлэн авсан шимт уусмалыг хадгалах болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн явуулах зорилгоор тусгай геомембран доторлогоо бүхий нийт 7 цөөрөм ашиглах бөгөөд тус үйл ажиллагаанаас бороожуулалт, уурын зуух, тээвэрлэлт, барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэл зэрэг нь байгаль орчинд сөрөг нөлөөлөлтэй харин суваг, цөөрөм нь хэвийн ажиллагаатай үедээ эерэг нөлөөлөлтэй байна. Харин байгаль орчны үзүүлэлтээс агаарын чанар, хөрс, газрын доорх ус зэрэг нь хамгийн их нөлөөлөлд өртөж байна. Агаар бохирдуулагч гол эх үүсвэр нь утаа болон тоосжилт юм. Харин катодын зэсийн үйлдвэрийн хувьд нөлөөлөл бага байна.

Хүснэгт 5. Эерэг сөрөг нөлөөлөл

№	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас БОН-д үзүүлэх нөлөөлөл	Овоолго /бороожуулах/	Суваг	Цөөрөм	SX-EW цех /уусган тандалт,электролиз/	Уурын зуух	Хүхрийн хүчлийн агуулах	Бараа материалын агуулах	Нүүрсний талбай	Шугам сүлжээ	Тээвэр	Цэвэрлэх байгууламж	Нийлбэр	Төмөр угаах шатлал	
Сөрөг															
1	Физик хүчин зүйл	Агаарын чанар	1	0	0	0	1	0	0	1	0	1	0	4	1
2		Гадаргын ус	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
3		Газрын доорхи ус	2	0	0	0	0	0	0	0	0	0	0	2	0
4		Хөрс /газрын гадарга, хэвлий/	1	0	0	0	0	0	0	1	0	2	0	4	1
5		Дуу шуугиан	0	0	0	1	1	0	0	0	0	0	0	2	1
6	Биологийн хүчин зүйл	Ургамал	0	0	0	0	0	0	0	0	1	0	1	1	
7		Амьтан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
Нийт			4	0	0	1	2	0	2	0	4	0	13	4	
Эерэг															
1		Агаарын чанар	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	1	

2	Физик хүчин зүйл	Гадаргын ус	0	0	1	0	0	0	0	0	0	0	0	0	1	0
3		Газрын доорхи ус	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
4		Хөрс /газрын гадарга хэвлий /	0	2	2	0	0	0	0	0	0	0	0	0	4	0
5		Дуу шуугиан	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0	0
6		Биологийн хүчин зүйл	Ургамал	0	2	2	0	0	0	0	0	0	0	0	4	0
7	Амьтан	0	1	1	0	0	0	0	0	0	0	0	0	2	0	
Нийт			0	5	6	0	0	0	0	0	0	0	0	11	1	

Хүснэгт 6. Нөлөөллийн хамрах хүрээ

№	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас БОН-д үзүүлэх нөлөөлөл	Овоолго /бороожуулах/	Суваг	Цөөрөм	SX-EW цех /уусган тандалт,электролиз/	Уурын зуух	Хүхрийн хүчлийн	Бараа материалын	Нүүрсний талбай	Шугам сүлжээ	Тээвэр	Цэвэрлэх байгууламж	Төмөр угаах шатлал	
1	Физик хүчин зүйл	Агаарын чанар	Т			Т			Т		Т		Т	
2		Гадаргын ус												
3		Газрын доорхи ус	Т		Т									
4		Хөрс /газрын гадарга, хэвлий/	Т								Т		Т	
5		Дуу шуугиан				Т	Т						Т	
6	Биологийн хүчин зүйл	Ургамал									Т		Т	
7		Амьтан												
Нийт			3	0	1	1	2	0	0	1	0	3	0	4

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт (тоосжилт, уурын зуухны утаа), гүний ус (уусмал нэвчих) болон газрын гадарга, хөрс, ургамал, амьтанд (барилга байгууламжийн өргөтгөл, шинэчлэл) сөрөг нөлөөлөл учруулахаар байна.

Цаашид хяналт мониторинг, сайжруулалт, нөхөн сэргээлт зэрэг арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлснээр болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх боломжтой.

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэ бүлгийн зорилго нь төслөөс үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлж, үргэлжлэх эрчим ба цар хүрээг тогтоох нөлөөллийг бууруулах буюу зайлсхийх, багасгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зорьж ажиллав.

2.1. Агаарын чанарт үзүүлэл нөлөөллийг бууруулах.

Хүснэгт 7. Агаарын чанарын сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Сөрөг нөлөөллүүд	Төлөвлөсөн ажлууд	Нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт	Төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв	Биелэлт (%)	Хавсралтын дугаар
1	Төслийн үйл ажиллагаанаас агаар дахь хүлэмжийн хийн агууламжийг нэмэгдүүлэх	Сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх. On-grid (16.2кВт-ын нарны цахилгаан станцыг байгуулж угаарын хийн ялгаралтаас сэргийлэх.)	Үйлдвэрийн талбай	Нарны цахилгаан станцын панелиудыг суурилуулсан газрын асуудлаас шалтгаалан шийдвэрийг хүлээж байна.	Дотоод нөөцөөр	-	100	Хавсралт 1. Нарны цахилгаан станц
2								
3	Тээврийн хэрэгсэл, хүнд машин механизмын хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх	Замаас үүсэх тоосжилтыг бууруулах – хурдны хязгаарыг дагаж мөрдүүлнэ. Тээврийн хэрэгслүүдэд байрлуулсан GPS-ийн мэдээнд хяналт тавих		Үйл ажиллагаанд ашиглаж байгаа тээврийн хэрэгслүүдэд байршуулсан GPS тогтмол хянаж ажилласан.	Дотоод нөөц	-	100	Хавсралт 2. GPS хяналтын зураг
4								
5								
6	Уурын зуухны үйл ажиллагаанаас агаарт бохирдуулагч хий цацагдах.	Дулааны технологит тохирсон нүүрс хэрэглэх		Жил бүр	Дэд бүтцийн цехийн төлөвлөгөөнд туссан		100	Хавсралт 4. Нүүрсний шинжилгээ
6		Зуухын яндангаас агаарт хаягдах утааны шинжилгээг хийлгэх, хяналт тавих	Уурын зуух	Жил бүр				100
Нийт							17,200.0	

2.2. Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах

Үйлдвэрийн ойр орчимд гадаргын усны нөөц байхгүй. Харин үйл ажиллагаанд усыг унд ахуйн, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, зам болон ногоон байгууламжийг услахад ашиглаж байна. Технологийн хэрэглээний ус нь шулуутгагчийн хөргөлтөнд, катод угаах, үйлдвэрийн цех доторхи нойтон цэвэрлэгээнд, уусмалын алдагдлыг нөхөх зориулалтаар хэрэглэгддэг. Үйлдвэрийн цэвэр усыг Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэртэй цэвэр усаар хангах гэрээг байгуулж, үндсэн шугамнаас авч хэрэглэж байгаа бол үйлдвэрийн ногоон байгууламж, зам талбайг гүний худгаас ашиглаж байна.

Хүснэгт 8. Усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Төлөвлөсөн ажлууд	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Биелэлт	Төлөвлөсөн төсөв	Биелэлт %	Хавсралт-ын дугаар
1	Ногоон байгууламжийн усалгаа, уурын зуухны үйл ажиллагаанд ашиглаж буй гүний усны нөөцөд хомсдол учирч болзошгүй	Гүний худгийн уст давхаргын ашиглалтын түвшинд хяналт тавих, зохих хэмжээнд ашиглах	Уурын зуух, ногоон байгууламж усалгааны худаг	Худагуудаас дээж авч лабораторид шинжлүүлэн хяналт хийж ажилласан.	ОХШХ-т тусгагдсан.	100	Хавсралт 6. Шинжилгээний харуу
2		Ус ашиглах дүгнэлтэнд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, хуулийн шаардлагын дагуу ус ашиглах гэрээг хийж, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөх.		Ус ашиглах дүгнэлт гаргуулан Сэлэнгэ голын сав газрын захиргаатай ус ашиглах гэрээг байгуулан хуулийн дагуу усны төлбөрийг төлөн ажиллаж байна.	Дотоод нөөц	100	Хавсралт 7. Ус ашиглах дүгнэлт Ус ашиглах гэрээ Усны төлбөрийн баримт
3	Уусмал алдагдаж, гүний усны бохирдол үүсч болзошгүй	Гүний усны 1 цооногт автомат түвшин хэмжигч суурьлуулж турших, мэдээллийг жигдрүүлэх.	Мониторингийн 1 цэгт	100.0-2 цооногт усны автомат түвшин хэмжигч суурилуулан холбогдох газруудтай мэдээллийг холбон ажиллаж байна.	30,000.0	100	Хавсралт 8. Түвшин хэмжигчийн акт
4	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааны доголдоос ус хөрсөнд алдагдаж газрыг доорх ус бохирдох магадлалтай	Цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын уснаас улирал тутамд дээж авч шинжлэх, шаардлагатай засвар үйлчилгээг тогтмол хийх.	Цэвэрлэх байгууламж	Улирал бүр ЭҮ-ийн химийн төв лаборатори, УЦУОШГ-т тогтмол шинжилгээг хийлгэж байна. Одоогоор стандартаас давсан үзүүлэлтгүй байна.	Дэд бүтцийн төлөвлөлийн зардлаар	100	Хавсралт 9 Шинжилгээний харуу
Нийт					30,000.0		

2.3. Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Газрыг зөв зохистой ашиглахтай холбоотой Монгол Улсын хууль, тогтоомжуудын шаардлагууд, байгаль орчны стандартууд болон төслийн Байгаль орчны нарийвчилсан үнэлгээний шаардлагуудад нийцүүлэн ажиллах зорилтын хүрээнд төлөвлөгөөг боловсрууллаа. Бид аливаа үйл ажиллагаанаас газар хөндөх, хөрс хуулах ажилд хяналт тавьж, шимт хөрсийг стандартын дагуу хадгалах, тухайн талбайд шаардлагатай нөхөн сэргээлтийг төлөвлөхөд Тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх ажлын журамыг баталж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажиллаж байна.

Хүснэгт 9. Газрын хэвлий, хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Төлөвлөсөн ажлууд	Биелэлт	Төлөвлөсөн төсөв	Зарцуулсан төсөв /төг/	Биелэлт %	Хавсралт
1	Газрын гадарга, хэвлий эвдэгдэх, доройтох	Хяналтгүйгээр газар хөндөхөөс сэргийлж “Ухалт малталын зөвшөөрөл авах, олгох,бүртгэл хөтлөх”	2025 онд нийт 7 удаагийн ухалт малталтын ажил хийгдэж хяналт тавигдсан байна.	Дотоод нөөц	-	100	Хавсралт 10. Зөвшөөрөл
2.	Үйлдвэрийн бүсэд хатуу хог хаягдал үүсэх	Эко өдөрлөгийг тогтмол хэрэгжүүлэх, үйлдвэр орчимд их цэвэрлэгээ хийх	2025 оны 4 сарын 11-ний өдөр Эко өдөрлөг зохион байгуулан үйлдвэр орчмын рог хаягдлыг цэвэрлэсэн.	1,000,0	-	100	Хавсралт 11. Тайлан
3.	Хөрсөн бүрхэвчийг хамгаалах	Газар хөндөх үйл ажиллагааны өмнө шимт хөрсний гүнийг тогтоож, тогтоосон хэмжээнд	2025 онд хийгдсэн ухалт малталтын ажлуудаар нийт 80м3 шимт хөрс хуулагдаж хадгалагдсан.	Дотоод нөөц	-	100	Хавсралт 12. Бүртгэл
4.		Шимт хөрсний хүнд металлын шинжилгээ хийлгэх	Нийт 29,589 м3 хөрс хадгалагдаж байна. Нийт УЦУОШГ-аас 4 удаа, SGS лабораторид 2 удаа хөрсний хүнд металлын шинжилгээ өгч ажилласан.	Дотоод нөөц	-	100	Хавсралт 13.Хүнд металлын дээж
5.		Шатах, тослох материалын хаягдлыг тусгайлан тосон авч, зөвшөөрөл бүхий байгууллагад хүргүүлэх	Нийт 800л хаягдал тос гарсан. “Монпити Ойл” ХХК-д гэрээний дагуу нийлүүлсэн.	Дотоод нөөц	-	100	Хавсралт 14. Гэрээ, дагалдах хуудас

3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар Зарлигийн дагуу “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд” 2022-2030 онд 3,0 сая модны тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх зорилгоор мод үржүүлгийн газрын төслийг боловсруулан Орхон аймагт хэрэгжүүлж, ажиллаж байна.

Хүснэг. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Биелэлт	Төлөвлөсөн төсөв	Төсөв	Хавсралт
1	Биологийн нөхөн сэргээлт	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд нийт тарих моддын ажлын төлөвлөгөө гаргаж, төрийн захиргааны байгууллагаар батлуулах.	1	Мод үржүүлгийн газрын үйл ажиллагааны төсөвт тусгасан зардлын дагуу	1 тэрбум 990 сая	Хавсралт 15 Мод үржүүлгийн тайлан
2		Мод үржүүлгийн талбайд модны тарьц, суулгацын нөөц бүрдүүлэх.	300			Хавсралт 16. Гэрээ
3		A1001 зам дагуу мөнгөлөг улиас тарих	240	3 100.0	3 100.0	Хавсралт 17. Гэрээ
Нийт					1 тэрбум 993 сая 100 мянга	

“Ачит- Ихт” ХХК нь 2014 оноос эхлэн “Бүх нийтээр мод тарих” үндэсний өдрийг тэмдэглэн A1001 зам дагуу дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд хийгдсэн хашаанд 240 ширхэг мөнгөлөг улиас тарьсан байна.

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

“Ачит- Ихт” ХХК-ийн катодын зэс ялган авах төсөл нь нутгийн биологийн олон янз байдалд эерэг нөлөө үзүүлэхийг эрмэлзэж байна.

Үйл ажиллагаа явуулж буй бүс нутгийн биологийн олон янз байдалд учирч болох эрсдэл буюу болзошгүй сөрөг нөлөөллийг шатлалтайгаар бууруулах зарчмыг баримталж зохион байгуулсан.

Хүснэгт 10. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Төлөвлөгөө	Арга хэмжээг хэрэгжүүлэх талбай	Тоо хэмжээ	Төсөв	Биелэлт (%)	Хавсралт
1	Голын гольдролыг хамгаалах	Хангал голын усны нөөцийг нэмэгдүүлэх, эрэг, хөрсний элэгдэл эвдэрлээс хамгаалах зорилгоор бургас моддыг тарих	Эрдэнэт хотын хаалганы дэргэд Хангал голын гольдрол дагуу	500	11000,0	100	Хавсралт 18. Гэрээ, акт
2		Хангал голын усны нөөцийг нэмэгдүүлэх, эрэг, хөрсний элэгдэл эвдэрлээс хамгаалах зорилгоор мөнгөлөг улиас моддыг тарьж, нутагшуулах		300	2500,0	100	Хавсралт 19. Гэрээ, акт
3		Голын гольдрол дагуу тарьсан моддыг хамгаалах хамгаалалтын хашаа барих		206*66м2	40000,0	100	Хавсралт 20. Гэрээ, акт
Нийт					53 500,0		

“Ачит-Ихт” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас газар ашиглах гэрээний дагуу 157.16 га талбайг ашиглах зөвшөөрөлтэй ба нийт 156.96 га талбай ашиглалтын идэвхтэй хэлбэрт байна.

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Үйлдвэрийн 1км-ийн бүсэд газар эзэмших, ашиглах эрхтэй айл өрх, аж ахуй нэгж, байгууллага байхгүй. Үйлдвэрээс 2.5-3 км зайд байрлах 6 малчин айл өрх амьдардаг. Иймд нөлөөлөлд өртөгч бүлгийн айл өрхийг шилжүүлэх асуудал төлөвлөгдөөгүй. Харин Гамшгийн үед компанийн үйлдвэрийн ажилтнуудыг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлсэн.

Хүснэгт 11. Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө

№	Төлөвлөгөөтэй эсэх	Хүн, хүчний тооцоо /штаб, мэргэжлийн анги/	Химийн хорт бодисын нэр, тоо хэмжээ	Техник хэрэгсэл		Бэлэн байдлын үеийн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл /төрөл, тоо ширхэг/						
				3	13	10	100	25	200	1000	20	1
1	“Ачит-Ихт” ХХК-ний гамшгаас хамгаалах ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу	Удирдлага Штаб: 11 хүн Мэргэжлийн анги: 23 хүн	Хүхрийн хүчил: H2SO4 – 7132.1 тн Органик хандлагч Ликс: 32.4 тн Кобальтын сульфат: 9.9 тн Гуартек: 2.2 тн Керосин: 411 тн	Автобус	Том оврын болон суудлын тэрэг	Хүчлэгс хамгаалах хувцас MSA	Резинэн бээлий 20х200	Резинэн гутал	Хошууч-Р-2	Амны хаалт	Нүүрний хаалт	Хороглох байр

№	Нөхөн олговрыг шийдвэрлэх арга хэмжээ	Ажилтны тоо	Нэг ажилтны даатгалын зардал	Нийт зардал	Даатгалын компани
1	Ажил олгогчийн даатгал	201	23,938,348	41,023,348	Бодь-Даатгал
2	Гэнэтийн ослын даатгал		9,045,000		
3	Эмчилгээний даатгал		8,040,000		
4	Хууль тогтоомжийн дагуу олгох нөхөн олговор	Эрсдэл гарсан үед өртсөн ажилтнуудад нөхөн олговрыг олгоно.			

6. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК нь МУ-ын хууль, дүрэм журмууд болон олон улсын стандартад нийцсэн компанийн дотоод журмыг боловсруулан хэрэгжүүлэхээс гадна хууль, журмын зүйл заалтын шаардлагын дагуу тухайн жилд хэрэглэсэн Химийн бодисын орлого зарлагын мэдээг тогтмол гаргаж Орхон аймгийн Байгаль орчин аялал жуулчлалын газар, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэн ажиллаж байна. Цаашид холбогдох баримт бичгийг боловсруулан мөрдлөг болгон ажиллана. 2025 оны байдлаар төслийн хүрээнд нийт 71 нэр

төрлийн химийн бодис хадгалагдан, ашиглагдаж байна. Ашиглагдаж буй химийн бодисууд нь бүгд ХАЛМ-тай бөгөөд шаардлагад үл нийцэж буй ХАЛМ-тай химийн бодис байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

Хүснэгт 12. Химийн бодисын менежмент

№	Болзошгүй сөрөг нөлөөлөл	Арга хэмжээ	Цар хүрээ	Тоо хэмжээ	Төсөв, төг	Хугацаа	Эрх зүйн баримт бичиг
1	Аюултай бодис асгарах	Химийн бодисын асгаралтын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний сургалтыг Орхон аймгийн ОБГ-тай хамтран зохион байгуулах	Химийн бодистой харьцаж ажиллаж буй нийт ажиллагсад.	1 удаа	2,000,00	1-р улирал	Хавсралт 21. Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль,
2	Гамшиг ослын эрсдэл	Гамшгийн эрсдлийн үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанд	Хэмжих боломжгүй	Эрсдлийн удирдлагын зардал	1-4-р улиралд	Хавсралт 22. Гамшигийн эрсдлийн үнэлгээ 2025
3		Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж хэрэгжүүлэх.	Нийт ажилтнууд	1 удаа		1-4-р улиралд	Хавсралт 23. Гамшигийн эрсдлийн үнэлгээ 2025
4		Химийн бодисыг хадгалах, ашиглах, тээвэрлэх үед гарч болзошгүй эрсдлийн үеийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх.	Үйлдвэрийн бүхий л үйл ажиллагаанд			2,000,00	Жилийн турш
5	Химийн бодисын ашиглалтад хяналт тавих	ХБ№1-12 маягтын дагуу бүртгэлийг тогтмол хөтлөх. /ХХБАБТХ-13.7, ХБАЗБХ-13/	Химийн бодис ашиглаж буй үйлдвэрийн бүхий л хэсэг	Дотоод нөөц	Дотоод нөөц	Жилийн турш	Хавсралт 25.Химийн бодисын тухай хууль
6	Сургалт	Химийн бодистой харьцан ажилдаг ажилчдад жил бүр химийн бодисын сургалтанд хамруулах	Химийн бодистой харьцаж ажилладаг лаборатори, уусгалт, EW, SX цехийн үйл ажиллагаа	Нийт 60 ажилтныг хамруулна.	Үйл ажиллагаа-Сургалтын зардал	Жилийн турш	Хавсралт 26.Химийн бодисын сургалтын тайлан

7	Үйлдвэрийн ажиллагсдын эрүүл мэндэд нөлөөлөх	Нэг бүрийн хамгаалах хэрэслээр хангах, хор саармагжуулах бүтээгдэхүүнээр хангах, эрүүл мэндийн үзлэгт жилд 1 удаа хамруулах	Үйлдвэрийн нийт ажилтнууд	209 ажилтныг	Үйл ажиллагааны – ХАБ-ын зардлар	Жилд 1 удаа	ХАБЭА-н тухай хууль
Нийт					4,000,000		

Химийн бодисыг тээвэрлэх, хадгалах, үйлдвэрлэлд ашиглах үед гэнэтийн ослоос эрсдэл үүсэж химийн бодисоор агаар, гадаргын болон газрын доорх ус, хөрс газрын гадарга бохирдсон тохиолдолд хяналт шинжилгээ хийх, эрсдэлийг арилгах ажлыг Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгаж ажиллаж байна.

7. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

№	Нэр	Төлөвлөлт	Биелэлт	Зарцуулсан төсөв	Биелэлт %	Хавсралтын дугаар
1	Хог хаягдлын менежмент нэвтрүүлэх	Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах нийт хаягдлын дахин ашиглах боломжийг нэмэгдүүлэх, эх үүсвэр дээр ангилалыг сайжруулах, түр хадгалах цэгийг стандартын дагуу тохижуулах	Үйлдвэрт хаягдлыг энгийн болон аюултай гэж ангилахаас гадна менежмент нэвтрүүлсэнтэй холбогдуулж энгийн хаягдлыг дахивар болон дахин боловсруулах боломжгүй хаягдал гэж ангилж байна. Ангиллын дагуу 1. Аюултай хог хаягдал 2. Цаасны хаягдал 3. Шил болон хуванцарын хаягдлын цэгүүд шинээр байгуулсан.	11,000,0	100	Хавсралт 27. Хог хаягдлын цэг байгуулсан ажлын тайлан
2	Ахуйн	Орон нутгийн эрх бүхий байгууллагатай хог хаягдлыг устгуулах гэрээ байгуулах, журам, нормативын дагуу төлбөрийг төлөх	Орхон аймгийн хот тохижуулах газартай гэрээ байгуулж тогтмол ахуйн хог хаягдлын цэгт тээвэрлэн хүргэж байна. Нийт 688м ³ хаягдлыг хуваарийн дагуу шилжүүлсэн.	8,698,0	100	Хавсралт 28. Гэрээ
3	Үйлдвэрийн	Уурын зуухны халуун үнсийг өөрийн талбайд хөргөж аюулгүй	Орхон аймгийн хот тохижуулах газартай гэрээ байгуулж тогтоосон	67,344,000	100	Хавсралт 29. Гэрээ

		болсон хойно тээвэрлэх	талбайд тогтмол үнсийг тээвэрлэн хүргэж байна. 5863тн-67 344 000 төгрөг			
4	Аюултай хог хаягдал	Тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, тээвэрлүүлэх, устгуулах	Цэцүүх трейд ХХК, Түмэн эгшиг ХХК-тай тус тус гэрээг байгуулж, аюултай химийн бодисын аливаа хаягдлыг устгуулсан. Түмэн эгшиг – 6332 кг – 20`772`245 (260ш ibc)	20,000,0	100	<i>Хавсралт 30. Гэрээ, дагалдах хуудсууд</i>
5	Химийн бодисын хаягдал крад	Хаягдлыг цуглуулж, овоолго дээрх зөвшөөрөгдсөн цэгт хаях	Нийт 580м3 хэмжээний крадны хаягдал гарч, овоолго дээрх тогтоосон цэгт хүргэгдсэн.	-	100	<i>Хавсралт 31 Крадны бүртгэл</i>
6	Хаягдал тос масло	Түр хадгалах, тусгай эрх бүхий байгууллагад шилжүүлэх, устгуулах.	Монпители ойлтой гэрээг байгуулж түлшний хаягдал тос, 800л масло-ыг устгуулсан.	-	100	<i>Хавсралт 32 Гэрээ, дагалдах хуудас</i>
7	Сургалт	Хог хаягдлын ангилан ялгалт, байгаль хамгаалах арга хэмжээний талаар менежментийн зөвлөх байгууллагатай хамтарч төлөвлөгөнөөий дагуу сургалт хийх.	Хог хаягдлыг ангилж хэвшүүлэх сургалтыг ажилтнуудад тогтмол явуулж, гэрээлэгч байгууллагууд болон иргэдэд тус тус 1 удаа хийсэн	-	100	<i>Хавсралт 33. Сургалтыг бүртгэл мэдээ</i>
8	Бүх нийтийн цэвэрлэгээн д орлоцох	Байгаль хамгаалах хавар, намрын сарын ажлын хүрээнд эзэнгүй дүүргийн хог хаягдлыг цэвэрлэх	Эзэнгүй дүүргийн цэвэрлэгээнд 58 ажилтныг оролцуулан 5.28-ны өдөр Сархиа ууланд цэвэрлэгээ хийн ажилласан.	-	100	<i>Хавсралт 34. Тайлан</i>
9	Дахивар хаягдал	Үйлдвэрийн хэмжээнд хог хаягдлыг тогтмол ангилан ялгаж дахивар хаягдлыг орон нутгийн тээвэр логистикийн төвд тогтмол шилжүүлэх	Хог хаягдлын менежмент ажлын хүрээнд хуванцар, цаас, шилний хаягдлыг дараах газруудад хүргүүлсэн. Бидэрт манхан ХХК- 300кг Эко түлш – 700 кг цаасны хаягдал Шинэ шил – 2.3 тн	-	100	<i>Хавсралт 35. Хүлээлгэж өгсөн мэдээ</i>
Нийт				90`760`495		

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллүүдийг тогтоох, түүнээс урьдчилан сэргийлэх, үүссэн нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг бодит судалгаа, шинжилгээнд үндэслэн хэрэгжүүлж байна. “Ачит-Ихт” ХХК орчны хяналт шинжилгээг “Агаар, гүний ус, хөрс”-нд Орхон аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний албатай хамтран хийж байна. Байгаль орчны аудитын зөвлөмжийн дагуу хөрс болон гүний усны хүнд металлын шинжилгээг SGS лаборатори болон ХАНЛАБ лабораториудад хийлгэсэн. Мөн өөрийн лабораторид хуваарийн дагуу 7 хоног бүрт тогтмол дээж авч шинжлэн, хяналт тавин ажиллаж байна.

Хүснэгт 14. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

№	Хяналт шинжилгээ хийлгэх үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Биелэлт	Биелэлт (%)	Хавсралт
1	<ul style="list-style-type: none"> NO₂ SO₂ 	Үйлдвэрийн 6 цэгээс агаарын хяналт хийх. улиралд 1, жилд 24 шинжилгээ	УЦУОШТ-с дээж авч шинжилгээ хийсэн. MNS4585:2016 стандартын ЗДХ давсан тохиолдол байхгүй.	100	Хавсралт 36. Агаарын шинжилгээ
2	Агаар орчныг бохирдуулагч элементийн хяналт шинжилгээ хийлгэх	Уурын зуухны яндангаас гарах утаанд шинжилгээ хийх байгууллагыг сонгох		100	Хавсралт 37. Шинжилгээний хариу
3	Хур бороо, үер буух, цаг уур: агаарын хэм, салхины хурд, харьцангуй чийг, даралт хэмжилтийг тогтмол хийх.		Сар бүрийн нэгэнд тогтмол мэдээ УЦУОШТ-с авсан. Дотоод үйл ажиллагаанд 1 станцийг ашиглаж тооцооллыг хийж байна.	100	Хавсралт 38. Цаг уурын мэдээ
4	Орчны агаар дахь тоосжилтын хэмжилт шинжилгээг хийлгэх. (Нийт тоос, Рм 2.5, Рм10)		Эрүүл ахуй, хор судлалын лаборатори ХХК-аар 5 цэгээс шинжилгээ хийлгэсэн. Стандартаас давсан үзүүлэлтгүй байна.	100	Хавсралт 39. Шинжилгээний хариу
Хөрсөн бүрхэвч, газар ашиглалт					
5	Хөрсний бүрхэвчийн хяналтын цэгүүдээс дээж авч шинжлүүлэх Тодорхойлох элемент: РН, NH ₄ , SO ₄ , Fe, PO	Үйлдвэрийн хөрсөн бүрхэвчийн хяналтын 5 цэгээс жилд 2 удаа дээж авч шинжилгээ хийлгэх	УЦУОШГ хөрсний дээжлэлт хийсэн.	100	Хавсралт 40. Шинжилгээний хариу
6	Элемент тодорхойлох: Cu, Mo, Cd, Zn, As, Pb, Cr, Ni		5 цэгээс хүнд элемент дээж авч хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлсэн.	100	Хавсралт 41. Шинжилгээний хариу
Гадаргын болон газрын доорх ус					
7	Гүний усны хяналтын цооногуудаас дээж авч хяналт тавих Тодорхойлох элемент рН, SO ₄ , ЖБ	Гүний усны хяналтын 10 цооногоос сар бүр дээж авч хянах.	Сар бүр аймгийн УЦУОШТ-с гэрээний дагуу ус агуулсан 8-н цооногоос дээжлэлт хийж 96 сорьц шинжилгээ хийсэн.	100	Хавсралт 42. Шинжилгээний хариу
8	Элемент тодорхойлох: Mo, Cd, Zn, As, Pb, Cr, Ni, Cu		8 цэгээс дээж авч SGS лабораторид шинжлүүлсэн.	100	Хавсралт 43. Шинжилгээний хариу
Нийт			10,240,000		

9. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэсийн үйлдвэр нь нийт 200 гаруй ажилтан, албан хаагчидтай бөгөөд мод тарих, орчныг засаж тохижуулах, хүн бүр байгаль хамгаалагч байх уриан дор хамтран ажиллахаас гадна компанийн удирдлагын менежментийн системээр хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, байгаль орчны асуудлыг цогц байдлаар авч үздэг.

Мөн хууль журам, стандартын хэрэгжилтийг хангах, шаардлагыг биелүүлэх зорилт тавин ажиллаж байгаа бөгөөд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Газрын чанарын улсын хянан баталгаа болон бусад эрсдэлийн үнэлгээ зэрэг хяналт, мониторингийг зохих хууль журмын дагуу тогтмол хийлгэж, үр дүн, зөвлөмж, шаардлагыг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна. 2025 онд дараах ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Хүснэгт 15. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

№	Нэр	Төлөвлөлт	Биелэлт	Зарцуулсан төсөв	Биелэлт (%)	Хавсралтын дугаар
1	Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартын магадлан хийлгэх.	Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартын магадлах аудит хийлгэх, гэрчилгээг сунгах	Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартын баталгаажуулалтыг хийлгэн ажиллаж байна.		100	Хавсралт 44 ISO14001:2015 сунгагдсан сертификат
2	“Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө”-ний бодлогын баримт бичигтэй болсон байна.	Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө	Хуулийн шаардлагын дагуу үйлдвэрийн овоолгын хэсэгчилсэн хаалтын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж холбогдох иргэд, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, УУХҮЯ-нд танилцуулж, саналыг тусган 2024 оны 02 сарын 07-ны А/68 тоот тушаалаар төлөвлөгөөг БОАЖЯ-нд хүлээлгэж өгсөн. 2025 онд тус төлөвлөгөөнд тусгасан уусмал цэвэршүүлэх туршилт Америкийн Ecotechnol ХХК-д хийгдэж, үр дүнг баталсан тул тоног төхөөрөмжийн үйлдвэрлэлийг хийлгэж байна.	295`900`0	100	Хавсралт 45 БОАЖ-ын сайдын тушаал, УУХҮЯ, Эрдэнэт үйлдвэрийн санал, Иргэдэд танилцуулсан ИНХ-н тогтоол

3	Нарны цахилгаан станц	1МВт чадалтай, 2МВт.ц багтаамж бүхий цэнэг хуримтлуур, нарны	Үйлдвэрийн цахилгаан хангамжийн системтэй зэрэгцээ ажиллах нарны цахилгаан станцийг барих ажлыг эхлүүлсэн. Одоогоор контролын байр баригдаж, тольнууд угсрагдахад бэлэн болсон байна. /Газрын зөвшөөрлийн асуудлаас түр зогссон./	4,151,575,0	100	Хавсралт 1.д Нарны цахилгаан станцын гүйцэтгэлийн мэдээ
Нийт			4 тэрбум 461 сая 375 мянга			

8.1.1 Уурхай, Уулын болон баяжуулах үйлдвэрийн нөхөн сэргээлт, хаалтын журмын дагуу “Хаалт, нөхөн сэргээлтийн менежментийн төлөвлөгөө”-ний бодлогын баримт бичигтэй болсон байна.

Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шаардлагын дагуу ТЭЗҮ-д тусгагдсан ашиглалтын 10 жилийн хугацаа дуусаж байгаатай холбогдуулан Хаалт нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг боловсруулах шаардлага үүссэн. Бид 2019 оноос хойш судалж, 2022 онд "Грийнлэнд прайндли" ХХК-тай хамтарч ажиллах гэрээ байгуулж хаалтын төлөвлөгөө боловсруулагдсан. Шинжилгээнд Эрдэм шинжилгээний хүрээлэн, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн болон их дээд сургуулийн эрдэмтдээр удирдуулсан баг ажилласан бөгөөд өмнө 2019 онд тус компаний 80 гаруй эрдэмтэн судлаачдаас бүрдсэн баг хамт олон үйлдвэрийн үйл ажиллагаанаас үзүүлж буй нөлөөллийг тодорхойлох, байгалийн бүрэлдэхүүний үндсэн өгөгдөл, нөлөөллийг нарийвчилан судлах Байгаль орчны цогц судалгааг агаар, хөрс, гүний ус болон овоолго дээрхи, нийт талбайн усны шилжилт хөдөлгөөний тодорхойлох зорилго бүхий геофизикийн судалгааг 1 жилийн турш гүйцэтгэсэн.

Тус судалгааны болон бусад холбогдох судалгааны суурь баримт бичгүүдэд тулгуурлан Хаалтын менежментийн төлөвлөгөөг боловсруулсан. Хаалтын төлөвлөгөөг боловсруулах ажлыг нийт 295’900’000 төгрөгний өртөгөөр гүйцэтгүүлж дууссан. Хуулийн шаардлагын дагуу үйлдвэрийн овоолгын хэсэгчилсэн хаалтын менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж холбогдох иргэд, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, УУХҮЯ-нд танилцуулж, саналыг тусган 2024 оны 02 сарын 07-ны А/68 тоот тушаалаар төлөвлөгөөг БОАЖЯ-нд хүлээлгэж өгсөн.

8.1.2 Байгаль орчны менежментийн тогтолцооны ISO 14001:2015 стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, баталгаажуулалтын аудит хийлгэн ажиллаж байна.

Байгаль орчны удирдлагын тогтолцооны ISO 14001:2015 стандартын баталгаажуулалтын ажил хийгдэж байна.

8.1.3 Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх замаар цахилгааны хэрэглээгээ бууруулах.

Лондонгийн металлын биржийн гишүүн байгууллага, олон улсын ISO 14001:2015 стандарт нэвтрүүлэгчийн хувьд хүлээсэн үүргийн дагуу сэргээгдэх эрчим хүчийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр зорьж ажлуудыг төлөвлөн гүйцэтгэж байна. 2018 онд захиргааны байрны өргөтгөлийг газрын гүний дулаанаар хангах ажлыг, 2022 онд үйлдвэрийн гадна 140ш гэрэлтүүлгийг өөр дээрээ цэнэг хуримтлуулагчтай нарны эх үүсгүүртэйгээр шийдвэрлэсэн бол 2023 онд үйлдвэрийн цахилгааны хэрэглээгээ хэсэгчилж хангах зорилгоор үйлдвэрийн цахилгаан хангамжийн системтэй зэрэгцээ ажиллах 1МВ чадалтай, 2МВт.ц багтаамж бүхий цэнэг хуримтлуур, 2.2МВт-ын нарны цахилгаан станц барихаар төслөө эхлүүлж 2025 онд газрын зөвшөөрлийн асуудлаас болоод түр зогссон байдалтай байсан бол ажил дуусаж 12 сард ашиглалтанд оруулахад бэлэн болсон.

10. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

“Ачит-Ихт” ХХК-ийн катодын зэс үйлдвэрлэх төсөл “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын үйлдвэрийн бүсэд орших бөгөөд энэ бүсэд байнгын оршин суугч байхгүй хэдий ч Байгаль хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажлууд түүн дотроо орчны хяналт шинжилгээний хөтөлбөр болон нөхөн сэргээлтийн ажлыг тогтмол хэрэгжүүлэхийн ач холбогдол, үр дүнг хэрхэн сум, багийн иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх арга замын талаар орон нутгийн хэлтэстэй ярилцан оновчтой арга хэлбэрийг сонгон хэрэгжүүлнэ.

Хүснэгт 16. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Биелэлт	Бие лэлт (%)	Хавсралт
1	Үйлдвэрийн удирдлагад	Сар, улирал тутамд тайлагнах	100	Хавсралт 46. Тайлан танилцуулсан мэдээ
2	Компанийн хамжээнд мэдээлэл танилцуулга хийх	Хагас жил, жилийн эцсээр тайлагнав.	100	
3	Баянцагаан багийн иргэдэд танилцуулах	10 дугаар сарын 28-ны өдөр нийт 32 иргэдэд жилийн тайлан хаалтын төлөвлөгөөний явцыг танилцуулсан.	100	
4	Орон нутгийн Байгаль орчин аялал жуулчлалын газарт	11 сарын 06-ны өдөр	100	
5	Эрх бүхий байгууллагад тайлангаа хүргүүлэх	Тогтоосон хугацаанд хог хаягдлын болон химийн бодисын ашиглалтын тайланг хүргүүлсэн.	100	

Хавсралт материалууд

Хавсралт 1,2 . Нарны цахилгаан станц, Хурдны хязгаарыг хянах GPS мэдээлэл

1. НАРНЫ ЦАХИЛГААН ҮҮСГҮҮРТЭЙ ГЭРЭЛТҮҮЛЭГ

Зорилго

Үйлдвэрийн аюулгүй ажиллагааг хангах, осолгүй байх, ажиллах орчинг сайжруулах, нарны эрчим хүчийг ашиглан сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлэх зорилгоор үйлдвэрийн орчинд **240кВт** бүхий Нарны цахилгаан үүсгүүртэй **90** гэрлийг байрлуулахаар төлөвлөсөн.

Биелэлт



	Хугацааны төлөвлөгөө	Гүйцэтгэл
1-р захиалга	Эхлэх 2023 он 02 сар 08 өдөр	2023 он 02 сар 08 өдөр
	Дуусах 2023 оны 06 сар 16	2023 он 06 сар 16 өдөр
2-р захиалга	Эхлэх 2023 он 08 сар 21 өдөр	2023 он 08 сар 21 өдөр
	Дуусах 2023 оны 11 сар 01	2023 он 12 сар 07 өдөр

	Төсөв	Гүйцэтгэл
1-р захиалга	494,398,000 төгрөг	481,229,932 төгрөг
2-р захиалга	270,787,220 төгрөг	270,787,220 төгрөг

2. ЦЭНЭГ ХУРИМТЛУУРТАЙ НАРНЫ ЦАХИЛГААН СТАНЦ

Зорилго

Үйлдвэрийн цахилгаан хангамжийн найдвартай байдлыг дээшлүүлэх; зардал хэмнэх; CO2 ялгаруулалтыг бууруулах, LME -2040 ногоон шилжилт хийх санаачлагын хүрээнд ногоон эрчим хүч ашиглан зэс үйлдвэрлэх, үйлдвэрийн жилийн цахилгаан эрчим хүчний хэрэглээний 12% ормчмыг үйлдвэрлэх

Чадал: 2.16МВт НЦС болон 2МВт.ц/1МВт.ц-аас доошгүй цэнэг хуримтлуурын систем угсрах

Биелэлт

2МВт.ц/1МВт.ц-аас доошгүй цэнэг хуримтлуурын систем угсран. Цаг үеийн нөхцөл байдалаас шалтгаалан ашиглаж эхлээгүй байгаа.

Цаг үеийн нөхцөл байдал, газрын зөвшөөрлөөс шалтгаалан НЦС-ын төсөл зогссон

Чадал: 2.16МВт НЦС болон 2МВт.ц/1МВт.ц-аас доошгүй цэнэг хуримтлуурын систем угсрах

	Хугацааны төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Эхлэх 2023 он 01 сар	2023 он 01 сар
	Дуусах 2023 оны 12 сар	- 2023 он 12 сар /БУА, тоног төхөөрөмж, зураг төсөл, ТЭЗҮ хүлээн авсан/ - 2024 он 12 сар /Тавил тооцоо, туршилт, байнгын ашиглалтад оруулах төлөв/


	Төсөв	Гүйцэтгэл
1	3,127,273,000 төгрөг	4,151,575,000 төгрөг

Тухайн төслийн ХО-аа нөхөх хугацаа

Цэнэг хуримтлуурын үр ашиг, жилд – 201.63 сая төгрөг

/2024 оны бизнес төлөвлөгөөгээр/

ХО-аа нөхөх хугацаа – 20.59 жил



Хавсралт 3. Зам усалгаа гэрээ, төлөвлөлт, акт

БАТЛАВ:
“АЧИТ-ИХТ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Д.НОМИН

1. 

ОГНОО : 1. 2025/03/17 1

AIC
АЧИТ ИХТ LLC



АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ
/Хайрган хучилттай автозамын дагуух мод болон замын усалгаа хийх/
№ 25/171-А

Энэхүү Ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г **НЭГ ТАЛААС** 4417399 тоот регистрийн дугаартай, Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Ачит-Ихт ХХК-ийн үйлдвэрийн байр хаягт орших “Далайн Хошууны Шинэс” ХХК (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Бадрах-Эрдэнэ,

НӨГӨӨ ТАЛААС 2788705 тоот регистрийн дугаартай, Монгол Улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1 Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар хаягт орших “Ачит-Ихт” ХХК (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж ХАБЭАБО-ны менежер Ж.Мөнхдархан нар (цаашид тус тусад нь “Тал”, хамтад нь “Талууд” гэх) Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл болон бусад хууль тогтоомж, олон улсын болон Монгол Улсын холбогдох норм, стандартыг үндэслэн дараах нөхцөлийг харилцан тохиролцсоноор байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Гэрээгээр Гүйцэтгэгч нь Захиалагчийн Орхон аймаг дахь катодын зэсийн үйлдвэрийн 10,8 км хайрган хучилттай автозамын дагуух мод болон замыг 4-9 дүгээр сард ажлын өдрүүдэд Хавсралт 1-т заасан давтамж, хуваарийн дагуу услах усалгааны ажил (цаашид “Ажил” гэх)-ыг холбогдох хууль, дүрэм, журам, ажлын төлөвлөгөө, стандарт, норм, нормативын дагуу гэрээний хугацаанд чанартай, мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн ажлын үр дүнг хүлээлгэн өгөх /цаашид “Ажлын үр дүн” гэх/, Захиалагч нь гэрээгээр тохиролцсон ёсоор төлбөрийг төлөхтэй холбоотой үүссэн харилцааг зохицуулна.
- 1.2. Дор дурдсан баримт бичгүүд нь энэ Гэрээний бүрдэл хэсэг болно.
 - (а) Хавсралт 1: Усалгааны хуваарь
 - (б) Хавсралт 2: Ажлын үр дүнг хүлээн авах акт
- 1.3. Гэрээт ажлыг нэг өдрийн 350,000.00 (гурван зуун тавин мянган) төгрөг байна. Нийт үнийн дүнд ажил гүйцэтгэхэд шаардлагатай бараа, материал, техник, тэнэг төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин механизм ашиглах, тээвэрлэхтэй холбогдсон зардал, гүйцэтгэгчийн ажиллагсдын цалин хөлс, хөдөлмөрийн аюулгүй байдлын зардал, томилолт, давагдашгүй хүчин зүйлстэй холбоотой зардал зэрэг энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүхий л зардлууд болон түүний ашиг, татвар, хураамж, гааль, НӨАТ тус тус багтсан болно.
- 1.4. Захиалагч нь Гэрээний зургаадугаар бүлэгт заасны дагуу ажлын үр дүнг хүлээн авч, төлбөрийг гэрээгээр тохиролцсон дүнгээр тогтоосон хугацаанд төлнө.
- 1.5. Ажил гүйцэтгэх хугацаа: 2025 оны 04 сарын 15-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаатай байна.
 - 1.5.1. Ажил эхлэх хугацаа: 2025.04.15
 - 1.5.2. Ажил дуусах хугацаа: 2025.09.30
 - 1.5.3. Ажлын үр дүнг хүлээлгэн өгч, актаар баталгаажуулах хугацаа: 2025.10.01
- 1.6. Гэрээг байгуулснаас хойш ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хүртэл Гэрээний үнийн дүн болон хугацаанд дор дурдсанаас бусад тохиолдолд өөрчлөлт оруулахгүй болохыг талууд харилцан тохиролцов.
 - 1.6.1. Захиалагчийн хүсэлтээр ажлын цар хүрээнд өөрчлөлт оруулсан тохиолдолд талууд харилцан тохиролцон, хугацаа болон үнийн дүнд өөрчлөлт оруулж болно.
 - 1.6.2. Гэрээг байгуулснаас хойш ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хүртэл хугацаанд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл тохиолдвол талууд харилцан тохиролцон, гэрээний хугацаанд өөрчлөлт оруулж болно.

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуудас 1 / 10
2025.03.13	Захиалагч 	Гүйцэтгэгч 	

- 1.7. Гүйцэтгэгч нь ажлыг хийж гүйцэтгэхдээ үйлдвэрлэлийн болон ажил гүйцэтгэж байгаа бусад этгээдийн хэвийн үйл ажиллагаанд саад учруулахгүйгээр зохион байгуулна
- 1.8. Гүйцэтгэгч нь ажлын байр, үйлдвэрийн талбайд Захиалагчийн дотоод болон аюулгүй ажиллагааны дүрэм, журмыг мөрдөж ажиллах бөгөөд орон нутгийн байгууллага, оршин суугчдад хүндэтгэлтэй хандаж ажиллана.
- 1.9. Гэрээнд хэрэглэгдэх нэр томъёог дараах утгаар ойлгоно.
- 1.9.1. “Гэрээ” гэж Талуудын хооронд байгуулсан Ажил гүйцэтгэх гэрээ болон гэрээний хавсралтыг;
- 1.9.2. “Эрх бүхий албан тушаалтан” гэж гэрээ, хэлцэл байгуулахад шууд болон шууд бусаар оролцож буй гэрээ батлах болон гэрээ байгуулахаар гарын үсэг зурах эрх олгогдсон этгээдийг;
- 1.9.3. “Эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолтой этгээд” гэж эрх бүхий албан тушаалтны эхнэр, нөхөр, тэдэнтэй хамт амьдарч байгаа гэр бүлийн бусад гишүүн, эцэг, эх, хүүхэд, ач, ээ болон ах, эгч, дүү, өөрсдийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшдэг компанитай хийгдэж байгаа хэлцлийн үр дүнгээс шууд болон шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа тохиолдолд уг гэрээнд оролцогч талуудыг;
- 1.9.4. “Сонирхлын зөрчил” гэж эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай дор дурдсан харилцаанд орохыг хэлнэ;
- А) Гэрээлэгч тал гэдэгт гэрээнд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
- Б) Гэрээний аль нэг тал болон эсхүл уг гэрээнд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа талын эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- В) Гэрээний аль нэг тал болон эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа талын толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
- Г) Гэрээний үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа этгээд;
- 1.10. Гэрээний 1.9.2 болон 1.9.3-т заасан эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь сонирхлын зөрчилтэй гэрээ байгуулахаас татгалзах үүрэгтэй.

ХОЁР. ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

- 2.1. Гэрээний төлбөрийг сар бүрийн эцэст талууд хамтарсан акт үйлдэн тухайн сарын ажлын гүйцэтгэлийг дүгнэж, гүйцэтгэлээр тооцон, Гүйцэтгэгчээс хүчин төгөлдөр нэхэмжлэлийг Захиалагчийн санхүүгийн газарт ирүүлснээс хойш 30 хоногт багтаан төлнө.
- 2.2. Гүйцэтгэгчийн төлбөр хүлээн авах дансны мэдээлэл:
Гүйцэтгэгчийн нэр: “Далайн Хошууны шинэс” ХХК
Банкны нэр: Хас банк
Дансны дугаар: 5005248864
- 2.3. Талууд шаардлагатай тохиолдолд гэрээний Төлбөр тооцоог гадаад валютаар хийх бол тухайн валютын ханшийг төлбөр төлөх өдрийн Монгол банкны ханшаар хөрвүүлж тооцно.
- 2.4. Төлбөр төлөх өдөр нь амралтын өдөр, нийтээр амрах баяр ёслолын өдөртэй давхацсан тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр төлбөрийг төлнө.

ГУРАВ. ШААРДЛАГАД НИЙЦҮҮЛЭХ

- 3.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг гүйцэтгэхдээ үйл ажиллагаандаа холбогдох хууль, дүрэм, журам, стандарт болон ХАБЭАБО-ны стандарт шаардлага, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд мөрдөн, батлагдсан ажлын даалгаврыг бүрэн биелүүлэн, гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэнэ.
- 3.2. Гүйцэтгэгч нь ажлыг гэрээнд заасан хугацаанд өөрийн хөрөнгө, багаж, техник хэрэгсэл, ажиллах хүчийг ашиглан мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэнэ.
- 3.3. Ажил гүйцэтгэхэд ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь аюулгүй ажиллагааны шаардлагад нийцсэн, бараа материал нь байгаль орчин, хүний эрүүл мэндэд ямар нэгэн сөрөг нөлөөгүй, чанар стандартын шаардлага хангасан байна.
- 3.4. Гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээ нь тусгай зөвшөөрөл шаардагдах бол холбогдох эрх бүхий мэргэжлийн болон төрийн байгууллагаас авсан хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөлтэй байна.

Огноо	Талууд гарын үсэг зурах	Хуудас 2 / 10
2025.03.13	Захиалагч _____ Гүйцэтгэгч _____	

- 3.5. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүргээ Захиалагчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй, дамжуулахгүй, давхар гэрээлэхгүй бөгөөд гүйцэтгэх ажилд зайлшгүй шаардлагатай туслан гүйцэтгэгчийг сонгох, гэрээ байгуулах шаардлагатай тохиолдолд урьдчилан мэдэгдэж, Захиалагчаас бичгээр зөвшөөрөл авна.
- 3.6. Захиалагчийн эрх бүхий этгээдээс Ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан шаардлага тавибал Гүйцэтгэгч хүлээн авч алдаа дутагдлаа залруулах, шаардлагад нийцүүлэх ажлыг нэн даруй хийж гүйцэтгэнэ.
- 3.7. Гүйцэтгэгч нь ажлыг батлагдсан ажлын даалгавар, хуваарийн дагуу гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд энэ талаар нэн даруй мэдэгдэж, Захиалагчид хамгийн ашигтай байх шийдлийг шуурхай гаргаж зөвшилцөн, нэмэлт гэрээ байгуулж ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
- 3.8. Зам усалгааны ажлыг бороотой өдөр хийхгүй.

ДӨРӨВ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ЗОХИЦУУЛАЛТ

- 4.1. Талууд ажил эхлэхийн өмнө гэрээт ажлын эрсдэл ба боломжийн ерөнхий үнэлгээг хийж эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэхдээ хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны тухай хууль тогтоомж, дүрэм журам, стандартад заасан болон дараах үүргийг хүлээнэ.
 - 4.2.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээр болон үйл ажиллагаа явагдаж байгаа газар /ажилдаа ирэх, буцах зам болон бусад/-т бүх үйл ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хариуцах бөгөөд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөн гэрээний хугацаанд өөрийн ажилтны эрүүл мэнд, амь нас, аюулгүй байдал, байгаль орчинд учирсан хохирлыг бүрэн хариуцна.
 - 4.2.2. Гүйцэтгэгч нь Захиалагчийн ХАБЭА, Байгаль орчны дүрэм, журам, аюулгүй ажиллагааны зааврыг чанд мөрдөн ажиллана.
 - 4.2.3. Гүйцэтгэгчийн ажилтнууд ХАБЭА-н сургалтад хамрагдсан сертификаттай байх ба аюулгүй ажиллагааны MNS 4969:2000 стандартад дурдсан Урьдчилсан, Ажлын байран дахь анхан шатны болон Давтан зааварчилгааг тухай бүрд нь өгч гарын үсэг зуруулсан байна.
 - 4.2.4. Захиалагч Гүйцэтгэгчийн ажилд хяналт тавих ХАБЭА-н ажилтныг томилох бөгөөд Гүйцэтгэгч нь ХАБЭА-н ажилтан болон Байгаль орчны ажилтны тавьсан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажиллана.
 - 4.2.5. Захиалагчийн ХАБЭА-н ажилтан ямар ч үед Гүйцэтгэгчийн ажилтнуудад алко тест /амьсгал дахь спиртийн агууламжийн/ болон бусад хяналт шалгалтыг явуулах эрхтэй бөгөөд шалгалтын хүрээнд тавьсан шаардлагыг Гүйцэтгэгч бүрэн хангаж ажиллана.
 - 4.2.6. Гүйцэтгэгч нь ажилтнууддаа стандартын шаардлага хангахуйц ажлын хувцас хамгаалах хэрэгсэл (тусгай гутал, нүдний шил, каск, гэрэл ойлгогчтой компанийн лого таних тэмдэг бүхий жигд ажлын хувцас, бээлий, уналтаас хамгаалах тоноглол г.м)-ээр бүрэн хангана.
 - 4.2.7. Гүйцэтгэгчийн бүх машин механизм нь авто техникийн үзлэгт хамрагдсан байх ба өргөгч кран нь улсын мэргэжлийн хяналтын байгууллагаас ашиглалтын зөвшөөрлийн хуудас авсан байна. Оператор нь эрх бүхий үнэмлэхтэй байна.
 - 4.2.8. Ажлыг гүйцэтгэхдээ галын аюулгүй байдал, чанар, эрүүл мэндийн шаардлага хангасан, байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөлөл үзүүлэх бараа материал ашиглана.
 - 4.2.9. Гүйцэтгэгч нь өөрийн хариуцан гүйцэтгэж буй ажилтай холбоотой гарсан үйлдвэрлэлийн ослыг Захиалагч болон холбогдох төрийн захиргааны байгууллагад дүрэм, журмын дагуу мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй.
- 4.3. Гүйцэтгэгч нь Ажилтны амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд мэдээлэх, ажил үүргээ гүйцэтгэхээс шууд татгалзана.
- 4.4. Гэрээний 4.1-4.3-т заасан аюулгүй ажиллагааг хангаагүйтэй холбоотой бүх эрсдэл, зардал, хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.

ТАВ. АЖЛЫН ҮР ДҮНГ ХҮЛЭЭН АВАХ ЖУРАМ

- 5.1. Захиалагч нь Гүйцэтгэгчээс сар бүрийн сүүлээр ирүүлсэн ажлын гүйцэтгэл дүгнэх хүсэлтийг үндэслэн Ажлын үр дүнг хүлээн авах Эрх бүхий албан тушаалтныг томилно.

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуудас 3 / 10
2025.03.13	Захиалагч _____	Гүйцэтгэгч _____	

- 5.2. Гүйцэтгэгч Хавсралт 2-д заасан ажлын үр дүн хүлээн авах акт үйлдэн, ажлын гүйцэтгэлтэй холбоотой бүх бичиг баримтыг үйлдэн энэхүү гэрээ, хуваарьт заасан шаардлагад бүрэн нийцсэн гэж үзвэл ажлын үр дүнг **Эрх бүхий албан тушаалтанд** хүлээлгэн өгнө.
- 5.3. Гэрээний талууд ажлын гүйцэтгэл дүгнэх акт үйлдэн баталгаажуулснаар ажлыг хүлээлгэн өгсөнд тооцно.
- 5.4. Гүйцэтгэгч ажил дууссан акт үйлдэн, ажлын гүйцэтгэлтэй холбоотой бүх бичиг баримт (ажлын актууд, тоног төхөөрөмжийн паспорт, гарал үүслийн бичиг, фото альбом гэх мэт)-ыг үйлдэн энэ гэрээ, ажлын даалгаварт заасан шаардлагад бүрэн нийцсэн гэж үзвэл Захиалагч хүлээн авна.

ЗУРГАА. ХАРИЛЦАА ХОЛБОО

- 6.1. Гэрээгээр тохирсны дагуу аливаа мэдэгдэл, албан бичиг, бусад баримт бичгийг бичгээр үйлдэх бөгөөд биечлэн болон цахим шуудангаар эсхүл Талуудын эрх бүхий этгээдүүд зөвшөөрсөн бусад хэрэгсэл доорх хаягаар хүргүүлнэ.

6.1.1. “Захиалагч”-ийн хувьд:

Нэр: “Ачит-Ихт” ХХК

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил -1 Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би тауэр, 21 давхар

Утас: (+976)-75951199, Дотуур дугаар #

И-мэйл: contact@achit-ikht.mn

№	Овог нэр	Албан тушаал	Цахим шуудан	Гар утасны дугаар
1.	<i>Ж.Мөнхдархан</i>	ХАБЭАБО-ны менежер	munkhdarkhan@achit-ikht.mn	75951199-203
2.	<i>Л.Бужмаа</i>	Байгаль орчны ажилтан	bujmaa.b@achit-ikht.mn	75951199-236
3.	<i>Л.Азжаргал</i>	Ахлах нягтлан бодогч	Azjargal.l@achit-ikht.mn	75951199 - 215

6.1.2 “Гүйцэтгэгч”-ийн хувьд:

Нэр: “Далайн Хошууны Шинэс” ХХК

Хаяг: Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг, Ачит-Ихт ХХК-ийн үйлдвэрийн байр

Утас: 99991980

И-мэйл: badrakh-erdene.b@achit-ikht.mn

- 6.2. Мэдэгдлийг талуудын аль нэг нь 6.1-д заасан хэлбэрээр хүргүүлсэн тохиолдолд хүлээн авсан гэж тооцно. Мэдэгдэл хүргүүлсэн хугацаа нь амралтын өдөр, нийтээр амрах, баяр ёслолын өдөртэй давхасан тохиолдолд дараагийн эхний ажлын өдөр хүлээн авсанд тооцно.

ДОЛОО. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 7.1. Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд ажлын үр дүнг дагалдах бичиг баримт, мэдээ мэдээллийн хамт бүрэн хүлээн авах эрхтэй.
- 7.2. Захиалагч нь ажлын гүйцэтгэлд хяналт тавих, зөвлөгөө өгөх, хамтран ажиллах, Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгэж буйг шалгах, шаардлага тавих, зөрчил дутагдлыг гүйцэтгэгчид мэдэгдэн засуулах эрхтэй.
- 7.3. Ажлын гүйцэтгэлийн тайлан болон бусад холбогдох бичиг баримтыг тухай бүр нь шалгаж хүлээн авах, хүлээлгэн өгөхийг шаардах эрхтэй.
- 7.4. Захиалагч гүйцэтгэсэн ажилд чанарын болон бусад дутагдал, доголдол илэрвэл ажлыг хүлээн авахаас татгалзах, ажлын үр дүн хүлээн авах үед болон баталгаат хугацаанд ажлын үр дүнд доголдол илэрвэл түүнийг үнэ төлбөргүй арилгуулах, хохирол нэхэмжлэхээр гомдлын шаардлага гаргах эрхтэй.
- 7.5. Захиалагч нь Гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажлын үр дүн нь чанарын шаардлага хангаагүй, батлагдсан ажлын хуваариас зөрж буруу, дутуу гүйцэтгэсэн бол Гүйцэтгэгчийн зардлаар доголдлыг арилгуулах эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлнэ.
- 7.6. Шаардлагатай тохиолдолд ажил гүйцэтгэхэд шаардагдах баримт бичиг, ажлын талбайг ажил гүйцэтгэгчид ажил дуусах хүртэл түр шилжүүлнэ.
- 7.7. Ажлын гүйцэтгэлийг хянах хариуцсан ажилтан томилж Гүйцэтгэгчид мэдэгдэнэ.

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуулаас 4 / 10
2025.03.13	Захиалагч 	Гүйцэтгэгч _____	

- 7.8. Хариуцсан ажилтан ажлын гүйцэтгэлд хяналт тавих, Гүйцэтгэгчийн хариуцсан ажилтныг шаардлагатай мэдээллээр хангах, холбогдох зааварчилгаа өгнө.
- 7.9. Гүйцэтгэгчийн ажил гүйцэтгэж байгаа инженер техникийн ажилтнаас гэрээт ажлыг гүйцэтгэхэд мэргэжил ур чадварын хувьд шаардлага хангахгүй ажилтан байгаа тохиолдолд Гүйцэтгэгчид солих хүсэлтийг гаргаж болно.
- 7.10. Захиалагч нь ажил гүйцэтгэх явцын хяналтыг тавих үед чанар, төсөв, бусад холбогдох шаардлагад нийцэхгүй аливаа дутагдал, доголдол илрүүлбэл нэн даруй гүйцэтгэгчид мэдэгдэнэ.
- 7.11. Иргэний хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

НАЙМ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 8.1. Гүйцэтгэгч нь гэрээт ажлыг хийж гүйцэтгэхдээ холбогдох хууль тогтоомж, норм, норматив, ажлын даалгаврыг удирдлага болгон ажлын үр дүнг баталгаажуулан тухай бүрт нь хүлээлгэн өгнө.
- 8.2. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн үүрэгт ажлыг хугацаанд нь мэргэжлийн өндөр түвшинд, чанартай хийж гүйцэтгэнэ. Гэрээт ажлыг хийж гүйцэтгэхдээ мэдлэг туршлага, ур чадвар бүхий мэргэшсэн ажилтантай, шаардлагатай тоног төхөөрөмжтэй байна.
- 8.3. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцад батлагдсан ажлын хуваарьт өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага үүсвэл тухай бүрт нь Захиалагчид албан бичгээр танилцуулан зөвшилцсөний үндсэн дээр ажлыг үргэлжлүүлнэ.
- 8.4. Ажлын чанар, үр дүнд муугаар нөлөөлөхөөр, Гүйцэтгэгчээс үл хамаарах ямар нэгэн нөхцөл байдал бий болсон бол нэн даруй Захиалагчид мэдэгдэнэ.
- 8.5. Захиалагчийн эрх бүхий албан тушаалтан, хяналтын инженерээс ажлын гүйцэтгэлтэй холбогдуулан санал, заавар, шаардлага, дүгнэлт өгвөл хүлээн авах, биелүүлэх, ажилдаа тусгах, алдаа дутагдлаа залруулна.
- 8.6. Гүйцэтгэгч нь гологдол, дутагдалтай, шаардлагад нийцээгүй ажлын гүйцэтгэлийг Захиалагчийн шаардлагын дагуу өөрийн хөрөнгөөр арилгах буюу шинээр хийх үүрэгтэй.
- 8.7. Гүйцэтгэгчийн буруутай үйлдэл, эс үйлдэхүгээс шалтгаалан Захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг нөхөн төлөх үүрэгтэй.
- 8.8. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх явцад гарсан хог хаягдлыг өөрийн зардлаар үйлдвэрийн бүсээс гаргаж, зохих газар хаях үүрэгтэй.
- 8.9. Иргэний хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ЕС. ХАРИУЦЛАГА

- 9.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүрэгтээ хүндэтгэлтэй хандах бөгөөд аль нэг тал нь үүргээ биелүүлээгүйн улмаас нөгөө талд учирсан нэмэлт зардал, төлбөр, хохирлыг бүрэн хариуцна.
 - 9.1.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй бол гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувьтай тэнцэх алдангийг хугацаа хэтэрсэн хоног тутмаар тооцож нөгөө талдаа төлнө.
 - 9.1.2. Алданги тооцох тухай гомдлын шаардлагыг хүлээн авсан тал хуанлийн 7 хоногийн дотор албан бичгээр хариу өгөх ба заасан хугацаанд хариу ирүүлээгүй тохиолдолд гомдлын шаардлагыг хүлээн зөвшөөрсөнд тооцно.
 - 9.1.3. Гэрээт ажлыг гүйцэтгэх явцдаа болон ажил гүйцэтгэж буй талбайд Хөдөлмөрийн тухай хууль болон ХАБЭА-н холбогдох хууль, дүрэм, журам зөрчсөнөөс үүдэн зөрчил гаргасан, хохирол учруулсан бол хохирлыг буруутай тал хариуцна.
 - 9.1.4. Гүйцэтгэгч нь гэрээний 1.10-д заасан үүргийг зөрчиж гэрээ байгуулсан нь хожим баримтаар тогтоогдож Захиалагчийн санаачилгаар гэрээ цуцлагдсан бол Гэрээний нийт үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг Захиалагч талд төлнө.
 - 9.1.5. Гүйцэтгэгч нь ажлын үр дүнг хүлээлгэн өгсөний дараа гэрээнд заасан чанарын шаардлага хангаагүй, цаашид ашиглах боломжгүй болсон, тогтоосон хугацаанд доголдлыг арилгаагүй, гэрээний хугацаанд үүргээ гүйцэтгээгүй бол гэрээг цуцалж, гэрээний төлбөр болон Гэрээний нийт үнийн дүнгийн 30 хувьтай тэнцэх хэмжээний торгууль төлнө.
 - 9.1.6. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх хугацааг хэтрүүлснээс захиалагчид хохирол учирсан бол учирсан хохирлыг нөхөн төлнө.
- 9.2. Талууд дараах нөхцөл байдал үүссэн тохиолдолд аль нэг талдаа гэрээ цуцлах мэдэгдлийг хүргүүлэн гэрээг дангаар цуцлах эрхтэй:
 - 9.2.1. Талуудын аль нэг нь дампуурах эсхүл бусад хэлбэрээр төлбөрийн чадваргүй болсон бол;

Огноо	Талууд гарын үзэг зурах		Хуудас 5 / 10
2025.03.13	Захиалагч 	Гүйцэтгэгч _____	

- 9.2.2. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авахаас үндэслэлгүйгээр татгалзсан эсхүл Гэрээгээр тохирсон төлбөр төлөх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуанлийн 30 /Гуч/ хоног болон түүнээс дээш хугацаагаар хожимдуулсан тохиолдолд Гүйцэтгэгчийн санаачилгаар;
 - 9.2.3. Ажлын үр дүнг хүлээлгэн өгөх хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуанлийн 30 /Гуч/ хоног болон түүнээс дээш хугацаагаар хоцроосон бол;
 - 9.2.4. Талууд гэрээний 1.9-д заасан хязгаарлалтыг зөрчиж гэрээ байгуулсан нь нотлох баримтаар нотлогдсон бол;
- 9.3. Аль нэг тал нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах санал гаргавал Нөгөө талын үйл ажиллагаанд учруулсан хохирлын төлбөрт гэрээний нийт үнийн дүнгийн 20 /Хорин/ хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг гэм буруутай тал нь төлөх үүрэгтэй.
- 9.4. Гэрээний 9.1, 9.2.2, 9.2.3, 9.2.4, 9.2.5-д заасан үндэслэлээр гэрээний нэг тал гэрээг хугацаанаас нь өмнө цуцалбал, нөгөө тал нь үйл ажиллагаанд учруулсан хохирол болон гэрээний нийт үнийн дүнгийн 30 /Гучин/ хувьтай тэнцэх хэмжээний торгуулийг төлнө.
- 9.5. Талуудын аль нэг нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчин, аюулгүй ажиллагаатай холбоотой гэрээнд заасан үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талдаа учирсан хохирлыг бүрэн хариуцан арилгана.
- 9.6. Талуудын аль нэг нь гэрээний 9.1-д заасны дагуу төлсөн алданги, торгууль нь Талуудын үндсэн үүрэг болон учирсан хохирлыг нөхөн төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 9.7. Гэрээгээр хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүй Тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс бусад тохиолдолд хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.
- 9.8. Талууд 9.1 болон 9.2-т зааснаас бусад тохиолдолд гэрээг дангаар цуцлахыг хориглоно.
- 9.9. Гэрээг байгуулах үндэслэл болсон Худалдагчийн гаргасан аливаа баталгаа нь Гэрээ байгуулагдсанаас хойш худал болох нь тогтоогдвол Гэрээ хүчин төгөлдөр бус гэж үзэж, Худалдан авагчид учруулсан хохирлыг бүрэн барагдуулна.

АРАВ. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 10.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл гэдэгт талуудаас үл хамаарах шалтгаанаар гэрээний аль нэг тал үүргээ биелүүлэхэд нөлөөлөх, урьдчилан таамаглах боломжгүй үйл явдал, нөхцөл байдлыг ойлгоно. Тухайлбал: Ган, зуд, үер, газар хөдлөлт, хүчтэй шуурга, гал, цахилгаан зэрэг байгалийн гамшигт үзэгдэл, халдварт өвчин, дайн, зэвсэгт бослого, иргэний дайн, хөдөлгөөн, дэлбэрэлт, нийтийг хамарсан ажил хаялт, үйлдвэрлэлийн хорттой болон аюултай бодисын асгаралт, алдагдал, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны ноцтой доголдол гэх мэт байна.
- 10.2. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийн үед үүрэг биелүүлэх хугацаа нь давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаагаар хойшлоно.
- 10.3. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэнийг мэдмэгцээ нөгөө талдаа нэн даруй боломжит хэлбэрээр мэдэгдэж, мэдэгдсэнээс хойш 10 хоногийн дотор МҮХАҮТ-ын “Гэнэтийн болон Давагдашгүй хүчин зүйлийн гэрчилгээ” /яаралтайгаар/ эсхүл Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн албан ёсны мэдээллээр баталгаажсан нотолгоог бичгээр хүргүүлнэ.
- 10.4. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл үүссэн тухай мэдмэгцээ нөгөө талдаа энэ гэрээнд заасны дагуу мэдэгдээгүй бол ирээдүйд үүсэх хохирлыг төлөх үүргээс чөлөөлөгдөхгүй.
- 10.5. Гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл нөхцөл үүссэн нь талуудыг гэрээний үүргээс чөлөөлөхгүй бөгөөд уг хүчин зүйлийн нөлөө арилсны дараа гэрээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
- 10.6. Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд автсан Тал нь тухайн хүчин зүйлийн улмаас учрах эрсдэл, хохирлыг бууруулах талаар тодорхой арга хэмжээ авсан байх үүрэгтэй. Хэрэв Гэрээнд заасан үүргээ бүхэлд буюу зарим хэсгийг нь давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гүйцэтгээгүй бол тухайн Тал нь давагдашгүй хүчин зүйлсийн шууд нөлөөллөөс хамаарч үүргээ гүйцэтгээгүйн улмаас бий болсон хохирлоос тэр хэмжээгээр чөлөөлөгдөх ба уг хүчин зүйл арилснаар үүргээ биелүүлэх үүрэгтэй.
- 10.7. Гэрээний үүргээ биелүүлэхэд саад болох гэнэтийн давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөс үүссэн нөхцөл байдал дууссан тухай талууд хоорондоо нэн даруй мэдэгдэнэ.

АРВАН НЭГ: МЭДЭГДЭЛ БОЛОН БАТАЛГАА

- 11.1. **Бүрэн эрх:** Энэхүү Гэрээнд гарын үсэг зурсан өдрийн байдлаар Гүйцэтгэгч нь гэрээг байгуулах болон Гэрээний нөхцөлүүдийг биелүүлэхдээ эрх бүхий байгууллагаас шаардлагатай бүх зөвшөөрлийг авсан болно.
- 11.2. **Үнэн зөв мэдэгдэл:** Гэрээний дагуу Гүйцэтгэгчээс Захиалагчид гарган өгсөн бүх баримт бичиг болон мэдээлэл, баталгаа нь бүгд үнэн зөв бөгөөд ямар нэгэн чухал фактын талаар худал

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуудас 6 / 10
2025.03.13	Захиалагч _____	Гүйцэтгэгч _____	

мэдэгдээгүй, Гэрээ үнэн зөв болоход зайлшгүй шаардлагатай аливаа чухал фактыг орхигдуулаагүй болно.

- 11.3. **Зөрчилдөөн байхгүй тухай:** Энэхүү Гэрээгээр тохирсон нөхцөлүүдийг биелүүлэх нь Гүйцэтгэгчийн дүрэм, журам болон ижил төрлийн бусад баримт бичгийн нөхцөл болзолтой зөрчилдөхгүй бөгөөд эдгээр нөхцөл, болзлын дагуу аливаа хувь хүн буюу бусад байгууллага, хуулийн этгээдээс зөвшөөрөл авах шаардлагагүй. Одоо болон ирээдүйд гарч болох аливаа шүүх, захиргаа, арбитрын шийдвэрийг биелүүлж байгаа Гүйцэтгэгчийн үүрэг нь энэхүү гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлэхэд ямар ч хэлбэрээр саад болохгүй. Гүйцэтгэгч нь Гэрээ байгуулсан өдрөөс хойш энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ ямар нэгэн хэлбэрээр Гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.
- 11.4. **Туршлага, ажиллах хүч, техникийн боломж:** Гүйцэтгэгч Гэрээний дагуу ажлыг гүйцэтгэхэд шаардагдах дадлага, туршлага, чадвартай, ажиллах хүч, тоног төхөөрөмжтэй болно.

АРВАН ХОЁР. БУСАД

- 12.1. **Гэрээ дуусгавар болох:** Талууд Гэрээгээр тохирсон үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж, баталгаат хугацаа дууссанаар гэрээний харилцаа дуусгавар болно.
- 12.2. **Хүчин төгөлдөр болох:** Талууд гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.
- 12.3. **Гэрээнд ашиглах хэл:** Гэрээ нь албан ёсны хэл болох Монгол хэлээр хийгдэх бөгөөд талуудын харилцах баримт бичиг нь Монгол хэл дээр байна.
- 12.4. **Хууль:** Талууд гэрээгээр тохиролцсон үүргээ хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.
- 12.5. **Маргаан шийдвэрлэх:** Талууд гэрээтэй холбогдон гарах маргааныг зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ. Дээрх хэлэлцээрээр гэрээний маргааныг талууд шийдэж чадахгүй нь илт тодорхой болсон бол аль ч тал Монгол Улсын шүүхэд хандах эрхтэй.
- 12.6. **Зөвшөөрөл:** Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбоотойгоор өөрийн болон ажилтны хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, ашиглахыг нөгөө талдаа зөвшөөрч байгаа бөгөөд тэдгээр мэдээллийг гагцхүү гэрээтэй холбоотой үйл ажиллагаанд ашиглах болохоо батлав.
- 12.7. **Нүүцлал:** Талууд гэрээ байгуулсантай холбогдон шууд болон шууд бусаар мэдсэн, олж авсан, Талуудтай холбоотой бизнесийн нууцад хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, баримт (Үүнд: бүх төрлийн гэрээ, хэлцэл, үнийн санал гэх мэт)-ийг нөгөө Талын зөвшөөрөлгүйгээр өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд эсвэл гэрээний нөгөө Талын эсрэг ашиглахгүй, аливаа гуравдагч этгээдэд амаар буюу бичгээр задруулахгүй, дамжуулахгүй байх үүргийг 3 жилийн хугацаанд хүлээнэ.
- 12.8. **Оюуны өмч:** Талуудаас Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ашиглагдсан мэдээлэл, баримт материал, ноу-хау, оюуны өмч, бараа тэмдэгт хамааралтай мэдээлэл, баримтууд нь (хэрэв байгаа бол) тухайн талын эзэмшил, өмчлөлд хэвээр үлдэнэ. Энэхүү Гэрээний үр дүнд бий болсон аливаа мэдээлэл, баримтууд нь Худалдан авагчийн өмчид тооцогдоно.
- 12.9. **Хавсралт:** Хавсралт 1,2 нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.
- 12.10. **Нэмэлт, өөрчлөлт:** Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ талаар ажлын 7 /Долоо/-оос доошгүй хоногийн өмнө нөгөө талдаа бичгээр мэдэгдэж, талууд тухайн асуудлаар зөвшилцөж чадсан тохиолдолд нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, Талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болсонд тооцно.
- 12.11. **Гэрээний нэгдмэл байдал:** Гэрээ нь Талуудын хооронд бичгээр үйлдэгдсэн бүх урьдчилсан тохиролцоо, мэдэгдэл, баталгаа болон хэлэлцээрийг орлох бөгөөд Гэрээ нь бүхэлдээ Гэрээгээр тохирсон харилцааг зохицуулсан үндсэн баримт бичиг болно.
- 12.12. **Тусгаар байдал:** Гэрээний аливаа заалт хууль бус буюу хүчин төгөлдөр бусад тооцогдсон нь Гэрээний бусад нөхцөлийн хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй бөгөөд хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.
- 12.13. **Гэрээний хувь:** Гэрээг хоёр хувь үйлдэх бөгөөд Талууд гарын үсэг зурж, нөгөө Талдаа хүргүүлснээр баталгаажсанд тооцно.

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хууцаас 7 / 10
2025.03.13	Захиалагч _____	Гүйцэтгэгч _____	

12.14. Дотоод хяналтын мэдэгдэл: Ачит-Ихт ХХК нь бизнесийн болон худалдан авалтын үйл ажиллагаандаа шударга тэгш журмыг баримталдаг. Хэрэв манай ямар нэгэн ажилтан албан тушаалаа хувийн ашиг сонирхолдоо ашиглаж байгааг анзаарвал та манай хариуцсан албанд мэдэгдэхийг хүсье. Таны нэр, хувийн мэдээлэл нууцлагдна. /Email: compliance@achit-ikht.mn. Утас: 75951199 (305), 85000828/

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“АЧИТ-ИХТ” ХХК- ИЙН
ХАБЭАБО-НЫ МЕНЕЖЕР
Ж.МӨНХДАРХАЙ

Огноо: / 2025.03.13 /

ЗМҮГ
Д.ЖАРГАЛСАЙХАН

Огноо: / 2025.03.13 /

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:
“ДАЛАЙН ХОШУУНЫ ШИНЭС”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.БАДРАХ-ЭРДЭНЭ

Огноо: / 2025.03.13 /



Огноо	Талууд гарын үсэг зурх		Хуудас 8 / 10
2025.03.13	Захиалагч	Гүйцэтгэгч	

“Ачит-Ихт” ХХК, “Далайн Хошууны Шингэс” ХХК-ийн хооронд байгуулсан 2025 оны 03 дүгээр сарын 17-ны өдрийн 25/171-А тоот гэрээний Хавсралт I



МОД БОЛОН ЗАМ УСАЛГААНЫ ЕРӨНХИЙ ХУВААРЬ

Сар	Нийт ажлын өдөр	Услах зам болон модны нийт урт /км/	Давтамж /өглөө, орой/	Услах зам болон модны нийт Зам км/өдөр	Услах зам болон модны нийт зам км/сар	Төлбөр /төг/ нөат-тай
4-р сар	10	5.4	2	10.8	108	3,500,000
5-р сар	11	5.4	2	10.8	118.8	3,850,000
6-р сар	12	5.4	2	10.8	129.6	4,200,000
8-р сар	6	5.4	2	10.8	64.8	2,100,000
9-р сар	7	5.4	2	10.8	75.6	2,450,000
Нийт	46					

Зам усалгаа бороотой өдрүүдэд хийгдэхгүй бөгөөд төлбөр гүйцэтгэлээр төлөгдөнө.

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуудас 9 / 10
2025.03.13	Захиалагч	Гүйцэтгэгч _____	

“Ачит-Ихт” ХХК, “Далайн Хошууны Шинэс” ХХК-ийн хооронд байгуулсан 2025 оны 03 дүгээр сарын 17-ны өдрийн 25/177-А тоот гэрээний Хавсралт 2

АЖЛЫН ҮР ДҮНГ ХҮЛЭЭН АВСАН АКТ

2025 оны 03 сарын 19-ны өдөр

№	Ажлын нэр төрөл	Хэмжих нэгж	Гэрээ ёсоор		Эцсийн гүйцэтгэл	
			Тоо	Дүн /нэгж/	Тоо	Дүн /нэгж/
1	Зоч уулсаа				43	15,050,000
2						
3						
4						
5						

Комиссын шийдвэр.

25/177-А тоот гэрээ гүйцэтгэл үргэлжлэн дагуу төслийн бүрэн гүйцэтгэж төл үзжээ бүртгэж авах. Нийт 43 өдөр уулсаа хийсэн.


Акт үйлдэж, баталгаажуулсан:

Ажил гүйцэтгэгч: Г.Мөнхбаяр
 Хүлээлгэн өгсөн: [Холбоо] / [Холбоо]
 Хүлээн авсан /нэгжийн удирдлага/: Ж.Номингаржав
 Комиссын гишүүд /нэгжийн ахлах ажилтан/: [Холбоо]
 Комиссын гишүүд /нэгжийн ажилтан/: Э.Намууржав

Акттай танилцаж, баталгаажуулсан:
 “Ачит-Ихт” ХХК-ийн Хуульч: [Холбоо]

Огноо	Талууд гарын үсэг зурах		Хуудас 10 / 10
2025.03.13	Захиалагч _____	Гүйцэтгэгч _____	

Хавсралт 4. Нүүрсний шинжилгээ-2025, уурын зуухнаас гарах хорт хийн агууламжийн тайлан



Хаяг: Монгол улс, Дархан-Уул аймаг, Шарын гол сум
Email хаяг: info@sharyngol.mn
Утас: 75050066
№17



“Шарын гол” ХК-ийн Чагарын лабораторийн шинжилгээний дүн

2025 он 3 сар /Ачит Ихт/

Огноо	Фракц	Вагоны тоо	Дээжийн н дугаар	Шинжилгээний үзүүлэлт											Вагоны дугаар				
				Нийт чийг,%	Аналитик дээжийн чийг,%	Үнсэлг,%		Дэгдэмхий бодисын агуулга,%		Хүхэр,%		Илчлэг, ккал/кг							
				Mt, %	M nd , %	A nd , %	A ^{db} , %	V nd , %	V ^{dbf} , %	Si nd , %	Si ^{db} , %	Q _b nd	Q _b nd	Q _{net} nd					
3/1/2025	0-50	3	679	15.60	2.10	23.80	24.31	32.70	44.13	0.68	0.69	5491.60	5421.02	4406.22	85403343	61094439	811992		
3/14/2025	0-50	3	801	16.30	2.80	15.20	15.64	35.30	43.05	0.68	0.70	6163.10	6091.72	4957.62	60012986	809277	85404283		
3/15/2025	0-50	3	811	17.30	5.10	20.60	21.71	32.60	43.88	0.68	0.72	5552.60	5481.95	4498.62	808683	811968	85400190		
3/16/2025	0-50	3	824	16.58	4.56	12.73	13.34	39.46	47.71	0.64	0.67	6308.23	6240.44	5150.43	813592	60017209	809327		
3/17/2025	0-50	3	835	15.24	1.79	22.95	23.37	32.48	43.16	0.64	0.65	5627.27	5560.29	4532.30	60019510	60015146	812032		
3/24/2025	0-50	8	873	13.80	2.00	17.40	17.76	33.30	41.32	0.66	0.67	5990.20	5920.91	4936.46	85400166-85400224-85403459	85400224-60074952	60733482-85400455	60068624	808287
3/29/2025	0-50	4	915	11.50	1.80	25.60	26.07	33.40	46.01	0.66	0.67	5407.40	5338.81	4558.75	60009669	85404663	88001425	88002373	
Житгэсэн дундаж		27		15.2	2.9	19.8	20.3	34.2	44.2	0.7	0.7	5791.5	5722.2	4720.1					

Хянасан:
Шинжилгээ хийсэн:

Химич
Лаборант



А.Аня
Б.Тунгалаг



"ШИЛИЙН УС" ХХК
"АЧИТ ИХТ" ХХК



**"АЧИТ ИХТ" ХХК-ИЙН ОРХОН АЙМАГТ
БАЙРЛАХ ҮЙЛДВЭРИЙН ЭЗЭМШЛИЙН ТАЛБАЙД
БАЙРЛАХ УУРЫН ЗУУХНЫ ЯНДАНГААР
ХАЯГДАХ УТААНД АГУУЛАГДАХ ХОРТ
БОДИСЫН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ
АЖЛЫН ТАЙЛАН**

Захиалагч: "Ачит Ихт" ХХК-ийн үйлдвэрийн
үйл ажиллагаа эрхэлсэн захирал

И.Батболд

Ерөнхий инженер

Ц.Галсүрэн

Дэд бүтцийн менежер

Ө.Сэлэнгэ

Гүйцэтгэгч: "Шилийн Ус" ХХК-ийн захирал

Б.Баттөр

Хариуцлагатай гүйцэтгэгч:

Доктор (Ph.D) Д.Даваацэрэн

Доктор (Ph.D) А.Түмэнбаяр

Улаанбаатар хот
2023 он

Хавсралт 5. Ус ашиглах дүгнэлт, усны гэрээ

 ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
УСНЫ ГАЗАР

УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ

Улаанбаатар хот

2025 оны 2 дугаар сарын 26 -ний өдөр Дугаар Е-2501-000031 Утас: 265528, 265578

1. Аж ахуйн нэгж байгууллага, захирлын нэр, утас, факс, улсын бүртгэлийн болон регистрийн дугаар

Оноосон нэр: Ачит-Ихт ХХК
Улсын бүртгэлийн дугаар:
Регистрийн дугаар: 2788705
Захирал: Номин
Холбоо барих дугаар: 75951199
Факс :
И-мэйл хаяг :

2. Төслийн нэр байршил

Төслийн нэр: Катодын зэсийн үйлдвэр
Байршил: Орхон, Баян-Өндөр
Харьяалагдах сав газар: Орхон голын сав газар
Хамраах салбар: Хүнд үйлдвэр
Төслийн дэлгэрэнгүй: Лондонгийн металлын биржийн гишүүн, үндэсний үйлдвэрлэгч “Ачит-Ихт” ХХК нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын хөвүүлэн баяжуулах технологид тохирохгүй, бага агуулгатай, балансын бус 2-р овоолго буюу үүсмэл ордыг ашиглан гидрометаллургийн аргаар катодын зэс боловсруулах үйлдвэрлэлийг 11 дэх жилдээ эрхэлж байна. Төслийн дэлгэрэнгүйг баримтаар хавсаргав.

3. Төсөл хэрэгжүүлэгчийн нэр

Ачит-Ихт

4. Ажиллах горим, хүчин чадал

Үргэлжлэх хугацаа	Ажиллах горим	Жилд ажиллах хоног	Хоногт ажиллах ажилчидын тоо	Хоногт ажиллах цаг
1	2 ээлжээр	365	201	24

5. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний хэмжээ

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
Уур боловсруулахад нөхөн сэлбэлтээр авч ашиглах усны	122465.0	м3	Ачит ихт ХХК-ийн 2025 оны бизнес төлөвлөгөөнд 122,465.0 тонн уур үйлдвэрлэхээр төлөвлөсөн. Үүнд

Ажлын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Тайлбар
хэмжээ			ашиглагдах ус ны 10%-ийг нөхөн сэлбэлтээр аваар тооцлоо.
Техникийн хөргөлт угаалга, цэвэрлэгээнд шаардлагатай усны хэмжээ	15119.0	м3	2025 оны ашиглалтын төлөвлөгөөнд төлөвлөж ирүүлсэн.
Уусган баяжуулахад шаардлагатай усны хэмжээ	6000.0	тонн	2025 оны бизнес төлөвлөгөөнд 6000тн зэс боловсруулахаар төлөвлөсөн.
Ногоон ббайгууламжийн усалгаанд ашиглах усны хэмжээ	24000.0	м2	БОННУ тайлангийн 63 дугаар хуудас. 24000м3 талбайг 147 хоног услахаар тусгасан.
Зам, талбайн усалгаа	26250.0	м2	ТЭЗҮ 204 дүгээр хуудас.
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	222.0	хоногт 1 хүн	БОННУ 62 дугаар хуудас

6. Усны эх үүсвэр, нөөц, хоногт ашиглах хэмжээ

Эх үүсвэр	Зориулалт	Усны нөөц (л)	Усны нөөц (м3)	Тайлбар
Гүний худаг	Усалгаанд	3.5	302.4	Ногоон байгууламж, Уурын зуухны усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангана.
Шугам сүлжээ	Технологийн хэрэгцээнд	0.93	80.352	Төслийн үнд ахуйн болон технологийн усны хэрэглээг Эрдэнэт Үйлдвэр ТӨҮГ-тай байгуулсан гэрээний дагуу төвлөрсөн шугамж сүлжээнээс жилд 110,000 м3 усаар хангахаар Усны газрын 2022 оны 06 сарын 24-ны дугаар 177 боломжит нөөцийн дүгнэлтэд тусгасан.

7. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ, нөхцөл

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан ААНБ : ЖЭМР ХХК
Холбоо барих : 88088576
Нэмэлт мэдээлэл:

8. Усны барилга байгууламжууд

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
Гүний худаг	302.4	2.5x2.0 метр хэмжээтэй, сандвичэн барилга
Усан сан	15000.0	ёроолын өргөн 15м, ёроолын урт 56м, далангийн урт 80м, усан сангийн гүн 5м.

Барилга байгууламж	Хүчин чадал (м3)	Хэмжээ хийц
		2мм зузаантай HDPE геомембран доторлогоотой, далангийн налуу m=2.5

9. Дамжуулах байгууламж

Хаанаас (эхлэх цэг)	Хаана хүртэл (төгсгөлийн цэг)	Шугамын голч, мм	Дамжуулах шугамын урт, м
	Хүүчин дамжуулах шугам хоолой	450	740.5

10. Онцгой нөхцөл

- Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу усны шугам, хоолой бүрд баталгаажсан онлайн тоолуур суурилуулах;
- Хаягдлын сангаас бохир ус нэвчиж ус, хөрс бохирдуулахаас сэргийлэх, үерийн далан, шуудууны аюулгүй байдлыг хангаж ажиллах;
- Усны тухай хуулийн 30.1.2-т заасны дагуу Усны хэрэглээ хариуцсан ус ашиглалтын менежер ажиллуулах үүрэгтэй тул хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд ус ашиглуулах дүгнэлт гаргахгүй байхыг анхаарах.

11. Усны зарцуулалт

Ажлын нэр	Тоо Хэмжээ	Хэмжих нэгж	Усны хэрэглээ, м3 (Норм)	Гүйцэтгэх давтамж	Хэмжих нэгж	Нийт ашиглах усны хэмжээ, м3	Хөнгөлөх усны хэмжээ м3	Төлбөр тооцох усны хэмжээ м3
Уур боловсруулахад нөхөн сэлбэлтээр авч ашиглах усны хэмжээ	122465.0	м3	1.0	1.0	Удаа	122,465.00	110,218.50	12,246.50
Техникийн хөргөлт угаалга, цэвэрлэгээнд шаардлагатай усны хэмжээ	15119.0	м3	1.0	1.0	Удаа	15,119.00	0.00	15,119.00
Уусган баяжуулахад шаардлагатай усны хэмжээ	6000.0	тонн	3.5	1.0	Удаа	21,000.00	0.00	21,000.00
Ногоон ббайгууламжийн усалгаанд ашиглах усны хэмжээ	24000.0	м2	0.004	157.0	Удаа	15,072.00	0.00	15,072.00
Зам, талбайн усалгаа	26250.0	м2	0.002	140.0	Удаа	7,350.00	0.00	7,350.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	222.0	хоногт 1 хүн	0.15	365.0	Хоног	12,154.50	0.00	12,154.50
Нийт						193,160.50	110,218.50	82,942.00

12. Урьдчилсан байдлаар тооцсон усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээ

Ажлын нэр	Төлбөр тооцох усны хэмжээ, м ³	Усны ангилал	Хөнгөлөх хувь хэмжээ, %	1 м ³ усны үнэ	Усны нөөц ашигласны төлбөр, ₮	Төлбөрөөс хөнгөлсөн дүн, ₮	Төлбөл зохих дүн, ₮
Уур боловсруулахад нөхөн сэлбэлтээр авч ашиглах усны хэмжээ	12246.50	Газрын доорх ус	0.0	74.18	908,384.14	0.0	908,384.14
Техникийн хөргөлт угаалга, цэвэрлэгээнд шаардлагатай усны хэмжээ	15119.00	Газрын доорх ус	0.0	1710.24	25,857,118.56	0.0	25,857,118.56
Уусган баяжуулахад шаардлагатай усны хэмжээ	21000.00	Газрын доорх ус	0.0	1710.24	35,915,040.00	0.0	35,915,040.00
Ногоон ббайгууламжийн усалгаанд ашиглах усны хэмжээ	15072.00	Газрын доорх ус	0.0	74.18	1,117,965.60	0.0	1,117,965.60
Зам, талбайн усалгаа	7350.00	Газрын доорх ус	0.0	197.80	1,453,830.00	0.0	1,453,830.00
Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглах усны хэмжээ	12154.50	Газрын доорх ус	0.0	79.40	965,115.92	0.0	965,115.92
Нийт	82,942.00				66,217,454.22		66,217,454.22

13. Үйлдвэрлэл, үйлчилгээнд усны нөөцийг хэмнэх эргүүлж ашиглах даалгавар

- Ахуйн хэрэгцээнээс гарч буй бохир усыг стандартын шаардлагад нийцтэл цэвэршүүлэн эргүүлэн ашиглах;
- Технологийн усыг эргүүлэн ашиглаж уурын зуухны яндангаас гарч буй утааны хийд агуулагдах үнсний барих системийн нэмэлт ус болгон ашиглах.

14. Тавигдах шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөгөө

Усны тухай хуулийн 28.6-д заасны дагуу Орхон-Чулуут голын сав газар болон Сэлэнгэ голын сав газрын захиргаанаас ус ашиглах зөвшөөрөл авч, зохих журмын дагуу гэрээ байгуулах;

Хаягдал усны дүгнэлтийг дараа оны эхний улиралд багтаан гаргуулах;

Усны тухай хуулийн 28.18-д зааснаар ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглахгүй байх;

Усны тухай хуулийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолой бүрд баталгаажуулсан онлайн тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, Төсвийн тухай хуулийн 23.6.5-д заасны дагуу төсөвт төвлөрүүлэх;

Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс илүү ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцохыг анхаарах;

Жил бүрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг үндэслэлтэй, үнэн зөв гаргаж байх;

Үйл ажиллагаа зогсох, тасалдах нөхцөл байдал үүссэн үед холбогдох төрийн захиргааны байгууллагуудад даруй мэдэгдэж ажиллах;

Усны тухай хуулийн 7.5-д заасны дагуу улсын усны мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардлагатай ус ашиглалтын тайлан (газрын доорх усны хяналт-шинжилгээний мэдээ, ус ашиглах зөвшөөрөл, гэрээ, гэрээ дүгнэсэн акт, усны нөөц ашигласны төлбөрийн баримт, ус ашиглалтын тоо, хэмжээ) -г 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор Усны газарт office@water.gov.mn цахим



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр

Дугаар 25/
336-А

Архангай аймаг

Нэг. Ерөнхий зүйл

Усны тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасны дагуу Засгийн Газрын хэрэгжүүлэгч агентлаг "УСНЫ ГАЗАР"-ын 2025 оны 02 дугаар сарын 26 -ний өдрийн Е-2501-000031 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Орхон-Чулуут голын сав газрын захиргааны даргын олгосон 2025 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн А/09 тоот ус ашиглуулах зөвшөөрлийг үндэслэн:

Ус ашиглуулагчийг төлөөлж Орхон-Чулуут голын сав газрын захиргааны газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн Үүрцайх овогтой Очирдулам, Ус ашиглагчийг төлөөлж Орхон аймаг Баян-Өндөр сум Баянцагаан баг улсын бүртгэлийн 901119055 тоот гэрчилгээ, 2788705 регистрийн дугаартай "АЧИТ ИХТ" ХХК-ийн ХБАЭАБО-ны менежер Ж.Мөнхдархан нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт: Гүний усыг ногоон байгууламж, мод усалгаанд ашиглах мөн уурын зуухны тэжээлийн зориулалтаар ашиглана.

2.2. Ашиглах усны хэмжээ:

Үйлдвэрийн орчмын ногоон байгууламжийн усалгаанд 15,072.0м³, зам талбайн усалгаанд 7,350.0м³, уур үйлдвэрлэхэд 12,246.5м³ газрын доорх ус ашиглана.

2.3. Усны чанар, найрлага эх үүсвэр:

Өөрийн эзэмшлийн худгаас ногоон байгууламж, зам талбайн усалгаа, уур үйлдвэрлэхэд ашигладаг.

2.4. Усны эх үүсвэрийн байршил:

Солбицол: х- 104°18'72" у- 49°01'91"

Усны барилга байгууламж: 4,3 х 3,5х 2,3 хэмжээтэй, 100мм-ийн хөөсөнцөр хавтан материалаар хийгдсэн барилгатай. Уурын зуух 24х30м, өргөтгөл 18х30х11м 10см зузаан чулуун хөвөнтэй сэндвич барилгатай.

Тоног төхөөрөмжийн нэр, марк, Насосын хүчин чадал: QJ-1.5 100/3Т-9 маркийн ус өргөгч, насосыг 80м гүнд байрлуулсан.

2.5. Хаягдал усны хэмжээ: Ахуйн хэрэглээнээс гарч буй бохир усыг стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлж эргүүлэн ашиглах

2.6. Хаягдал усан дахь бохирдуулах бодисын хэмжээ:

2.7. бохир ус цэвэрлэх барилга байгууламжийн байршил , хүчин чадал, технологи, цэвэрлэгээний арга, түвшин: Ахуйн бохир ус цэвэрлэх 25м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай механик болон биологийн цэвэрлэгээ, цэвэрлэсэн усыг халдваргүйжүүлэх төхөөрөмж, нөөцийн усан сан, цэвэрлэсэн усаа нөөцлөх полиэтилен хулдаасаар доторлосон 2 цөөрөмтэй цэвэрлэх байгууламжийг ашигладаг.

2.8. Усны эх үүсвэрийг хамгаалах, усны нөөц хомсдох, бохирдохоос хамгаалах арга хэмжээ:

2.9. Усны тоолуурын нэр төрөл дугаар: LXSG-40 төрлийн 2 тоолууртай.

1. №202002109 дугаартай -Уурын зуухны уур боловсруулахад нөхөн сэлбэлтээр авч ашиглах

2. №202002049 дугаартай- Зам болон ногоон байгууламжийн усалгаанд ашиглах зориулалттай. 2 тоолуурын баталгаат хугацаа 2026.06.14 болон 2026.06.20-нд дуусна.

2.10. Ус ашигласны нэгж төлбөрийн хэмжээ:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг "УСНЫ ГАЗАР"-ын дүгнэлтээр урьдчилсан байдлаар гаргасан уур үйлдвэрлэх зориулалтаар 12'246.5м³ газрын доорх усны 908,384.1 төгрөг, зам талбайн усалгааны зориулалтаар 7'350.0м³ газрын доорх усны 1,453,830.0төгрөг, ногоон байгууламжийн усалгаанд 15'072.0 усны 1,117,965.60 төгрөгийг тус тус ногдуулсан байна. Нийт **3'480,179.7** төгрөг.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу усны төлбөрийг 2025 оны 12 дугаар сарын 01-ний дотор Орхон аймгийн Төрийн сан банкны дансанд төлж барагдуулна. Усны нөөц ашигласны төлбөр төлсөн баримтын хуулга, усны дээжид хийсэн шинжилгээний дүн, зэргийг Орхон-Чулуут голын сав газрын захиргаанд тухай бүр ирүүлнэ. Засгийн газрын 2018 оны 391 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу зөвшөөрсөн хэмжээнээс хэтрүүлэн ашигласан усны төлбөрийг шатлан өсгөж тооцно.

2.11. Хаягдал усан дахь нэгж бохирдуулах бодист ногдох бохирдуулах бодисын хэмжээ:

Улирал бүр хаягдал усны холимог сорьц авч, Орхон аймгийн байгаль орчны итгэмжлэгдсэн лабораториор шинжилгээ хийлгэж, хариу дүнг улирал бүр сав газрын захиргаанд ирүүлнэ.

Гурав. Талуудын эрх, үүрэг

3.1 Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 13.1.1, 18.1.4, 19.1.4, 26.1, 30.1, 31.1-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл, хаягдал усны талаарх дүгнэлт, хаягдал ус зайлуулах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3. Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэн тэмдэглэл үйлдэнэ.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Гэрээг дор дурдсан үндэслэлээр хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.5.1 Ашиглаж байгаа усны эх үүсвэр тусгай хэрэгцээнд шилжсэн;

4.5.2 Аль нэг тал татан буугдсан бол

4.6 Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ус ашиглуулагчийг төлөөлж:

Орхон-Чулуут голын сав газрын захиргааны Газрын доорх усны нөөц, хяналт шинжилгээний асуудал хариуцсан мэргэжилтэн

Y.Очирдулам/

Хаяг: Архангай аймаг Эрдэнэбулган сум. 3-р баг, Монгол даатгалын байр Орхон-Чулуут голын сав газрын захиргаа
Харилцах утас: 99208331

Ус ашиглагчийг төлөөлж:

“Ачит Ихт ХХК-ийн ХАБЭАБО-ны менежер

Г.Ж. Мөнхдархан/

Дэд бүтцийн менежер

O.Сэлэнгэ/

ЗМҮГ

D.Жаргалсайхан/

Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо, Стадион оргил-1, Чингисийн өргөн чөлөө-6, Кэй Би Таур, 21 давхар Үйлдвэрийн хаяг: Орхон аймаг, Баян-Өндөр сум, Баянцагаан баг
Утас: 75951199 (314), 99205427



УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2025 оны 05-р сарын 05-ны өдөр

Дугаар 02

Орхон аймаг

25/307-А

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Усны тухай хуулийн 28.4, 28.6, 28.7, 29.1-д заасны дагуу Усны газрын гаргасан 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн E-2501-000031 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Сэлэнгэ голын сав газрын 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн A/09 тоот ус ашиглах зөвшөөрлийг үндэслэн Ус ашиглуулагчийг төлөөлж Сэлэнгэ голын сав газрын захиргааны дарга М.Чулуунзагд, Ус ашиглагчийг төлөөлж Орхон аймаг Баян-Өндөр сум Баянцагаан баг 901119055 улсын бүртгэлийн дугаартай, 2788705 регистрийн дугаартай “Ачит-Ихт” ХХК-ийн Үйлдвэрийн захирал И.Батболд нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 1 (нэг) жилийн хугацаатайгаар байгуулав.

Хоёр. Гэрээний гол нөхцөл

- 2.1. Ус ашиглах зориулалт: Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар
- 2.2. Ашиглах усны хэмжээ: 48,273.5 м³/жил – 132.25 м³/хоног
